

1. АРИУН ОХИНООС ХҮҮ МЭНДЭЛНЭ (Лук 1:26-38)

Суурь ойлголт: Энэ үйл явдал тохиолдох үед Мариа хорь ч хүрээгүй залуухан охин байсан байх. Тэр Иосеф гэдэг мужаан залуутай гэрлэхээр сүй тавьсан байжээ. Хуучин гэрээний дагуу бол гэр бүл болохоосоо өмнө хамт унтахыг хатуу хориглодог байв.

1. Мариа ямар зан ааштай охин байсан бол? Та энэ сэдвээс ямар дүгнэлт хийв?
 - Бурхан Марь хоёрын холбоо ямар байсан бэ?
 - Жижигхэн хот Назар дахь Мариагийн өдөр тутмын амьдралыг та төсөөл дөө. Юу түүнд баяр баясгалан өгч харин юу түүнд шанлал авчирдаг байсан бол?
2. Их Эзэн яагаад энэ залуухан охиныг өөрийнхөө хүүгийн эх болгохоор сонгосон бэ?
 - Тэнгэр элчийн мэндчилгээг сонсоод Мариа ихээхэн цочиж сандарсны учир шалтгаа юу вэ? /29/
3. Их Эзэн Габриелыг Мариа уруу яах гэж явуулсан бэ?
 - 32-33-р ишлэлүүдийг унш. Эндээс харахад Мариа төрүүлэх хүүхдийнхээ тухай юу мэдэж авсан гэж та бодож байна вэ? Та өөрийн үгээр хэлнэ үү.
4. Мариа тэр үед хүнтэй ойртоогүй охин байсан. Ийм байтлаа хүүхэд төрүүлнэ гэдэгтээ тэр яаж итгэлтэй байж чадсан бэ? (Өөрөөр хэлбэл жирэмслэлтийн ямар ч шинж тэмдэг илрээгүй байхад.)
 - Өнөө үеийн ихэнхи хүмүүс яагаад энэ ер бусын жирэмслэлтэнд итгэж ядан байдаг вэ?
5. Матайн сайн мэдээнээс харвал Иосеф ч гэсэн анх энэ ёр бусын жирэмслэлтэнд итгэж ядан байсан. Есүсийн эх болсноороо хожим нь ирэх зовлон бэрхшээлийг тэр мэдэж байсан бол энэхүү Эзэний дуудлагыг хүлээж авах байсан болов уу?
6. Габриел Мариад “Чи Бурханы ивээлийг хүртжээ” гэж 2 дахин хэлжээ. /28, 30-р ишлэл/ “Ивээл” гэдэг үг нь гэмд үзүүлэх уучлал гэсэн утгатай үг ажээ. Энэ уучлал Мариа-д яагаад шаардлагатай байсан бэ?
7. Та нар амьдралд тохиолдох хүнд хэцүү сорилт бэрхшээлүүдийг дэндүү хүнд, Бурхан ч яаж ч чадахааргүй тийм хэцүү гэж боддог байх. Тэгвэл 37-р ишлэлийг уншаад, үүнийгээ өөрийнхөө хэцүү асуудалд ч мөн хандуулаад үзээрэй. Энэ ишлэл нь таны одоогийн нөхцөл байдал хэрхэн үйлчилж байна вэ?
8. 30-аад жилийн хойно Мариа хүүгийнхээ цовдлуулсан загалмайн дор зогсож байхдаа 32; 33-р ишлэлүүд дээрх Бурханы амлалтуудын талаар юу гэж бодож байсан бол?
9. Хэрвээ Бурхан танд "өршөөл ивээл" дүүрэн амьдралыг "зовлон бэрхшээл" - тэй амьдралын хамтаар санал болговол та түүнд ямар хариу өгөх вэ?

2. ТАЛЫН ХОНЬЧИД (Лук 2:8-20)

Суурь ойлголт: Есүсийн амьдарч байсан үеийн хоньчид нэлээд дорд үзэгддэг байжээ. Учир нь Саббат буюу амралтын өдрийн хуулыг тэд сахидаггүй байсан. Жишээлбэл тэд шүүхэд гэрчээр оролцох эрхгүй байлаа. Хуучин гэрээ номноос харахад тэнгэр элчүүд зөвхөн Абрам, Эзекиэл, Даниел зэрэг агуу хүмүүст харагджээ.

1. Эдгээр малчдын Иудэа уулан дахь өдөр тутмын амьдрал нь ямархуу байсан бол? Тэднийг баярлуулдаг болоод зовоодог байсан зүйлс нь юу байв?
 - Их Эзэний хуулыг сахиж чаддаггүй эдгээр хоньчид Бурхантай ямар холбоотой байсан бол?
2. Иерусалим Бетлехемтэй маш ойрхон бөгөөд тэнд олон шүтлэгтэй хүмүүс амьдардаг байв. Тэгвэл тэнгэр элчүүд яагаад тэдгээр шашинлаг хүмүүст биш харин хоньчдод үзэгдсэн бэ?
3. 9-р ишлэл дээр хоньчид их айсаныг өгүүлсэн байна. Тэд юунаас ингэтлээ их айсан бэ?
 - Өнөөдөр та чухам юунаас хамгийн их айж байна вэ? (Та үүнийг өөрөө өөртөө хариулж болно.)
4. Тэнгэрэлчийн ямар үг нь хоньчдыг илүү ихээр баярлуулсан бэ? /10-12-р зүйл/
 - Ишлэл 10-11 дахь үгсийг тэнгэр элч нар таньд хэлж байна гээд төсөөлөөд үз. Та өөрийгөө баярлана гэж бодож байна уу? Яагаад? Яагаад үгүй гэж?
 -
5. Удаан хүлээсэн Аврагч нь Тэжээлийн тэвшинд нойрсож байгаа гэдгийг сонсоод хоньчид юу бодоцгоосон бол?
 - Дэлхийг аврах Аврагчийг угаалгын түмпэнд нойрсож байгаа гэж дуулбал танд ямар санагдах вэ?
6. Бохир, хүйтэн газар хорт нян болоод өстөн дайснуудынхаа дунд мэндэлсэн тэрхүү Аврагчийн төлөө тэнгэр элчүүд хөөрөн баярлах болсон нь ямар учиртай вэ? /13-14/
 - Ямар учраас Аврагч маань иймэрхүү нөхцөл байдалд төрсөх ёстой байсан бэ?
7. Бурхан яагаад хүүгээ төрөнгүүт нь бусад хүмүүст харуулахыг хүссэн бэ?
8. Хоньчид харанхуй шөнөөр саравчийг яаж зөв олж ирж чадсан бэ?
 - Тэжээлийн тэвшин дотор хэвтэж буй нялх хүүг Их Эзэн Христ мөн гэж итгэх ямар үндэслэл тэдэнд байсан бэ?
9. Нилээд хүндхэн шөнийг өнгөрөөгөөд байж байсан Мариа, Иосеф 2-ыг хоньчид хэрхэн урамшуулсан бэ?
 - Бурхан яагаад тэнгэр элч нарыг биш харин хоньчидыг Мариа ба Иосеф хоёр луу илгээсэн бэ?

10. Христийг мэндэлсэн тэр шөнө хоньчид олон хүмүүст өөрсдийн үзсэн харснаа дуулгажээ. Гэвч дуулсан хирнээ тэдгээр хүмүүс яагаад Их Эзэнийг магтахаар ирээгүй вэ?

11. Есүс нэр алдартай болох хүртэл 30 гаран жил өнгөрсөн. Тэр үед хоньчидын ихэнх нь насан барсан байсан. Шинээр төрсөн аврагчтай уулзсны дараагаар тэдгээр хоньчидын амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бол? Өөрчлөгдөөгүй зүйл бий юу?

- Энэ үйл явдал болсноор хоньчид Бурхантай харьцах харилцааныхаа талаар юу мэдэж авсан бэ?

БАЯРТ МЭДЭЭ: Христийн мэндэлсэн тэр шөнө тэнгэр элчүүд хөөр баяр, амар тайван байдлын тухай дуулцгааж байжээ. Энэхүү амар тайван, баяр баясалын төлөө Есүс өр төлөөсийг төлөх ёстой болсон. Есүс тэжээлийн тэвшинд хэвтэж байхдаа өр төлөөсийг төл эхэлсэн бөгөөд загалмай дээр төлж дуусгасан юм.

3. АННА БОЛОН СИМЕОН (Лук 2:25-38)

Суурь ойлголт: Иосэф Мариа 2 сүмд ердөө л хоёрхон шувуу өргөсөн бөгөөд энэ нь тэдний ядуу байдлыг харуулжээ. Үүнийг /Левит 12:7-8/ - тэй харьцуулна уу? Тэр үед олон хүмүүс Мэсиаг ирнэ гэж хүлээж байсан бөгөөд тэдний ихэнх нь түүхийг өөрийн эрх мэдэл хүч чадлаа бүгдэд илчлэнэ гэдэгт итгэж байжээ.

1. Гэрлээд 7-хон жилийн дараа эр нөхрөө алдсан Аннагийн туулж өнгөрүүлсэн амьдрал ямар байв. /36/
 - Тэр үед дахин гэрлэх нь ердийн зүйл байсанв Анна яагаад дахин гэрлэхийг хүсээгүй вэ? Олон шалтгаануудыг ол.
 - 50-60 жил бэлэвсэн амьдарсан Аннагийн хувьд амьдралынх нь утга учир юунд оршиж байсан бол?
2. Анна юуны төлөө өдөр шөнийг ч үл хайхран олон жилийн турш сүмд ирж залбирдаг байсан бол?
 - 38-р ишлэл бидэнд Аннагийн итгэлийн талаар юуг харуулж байна вэ?
3. Есүстэй уулзах өдрийг хүртэлх Симеоны туулж өнгөрүүлсэн амьдралыг төсөөл. Амьдралынх нь баяр баясгалан, зовлон шаналгаа нь юу байсан бол? /25-26/
 - Бурханы амлалт нь Симеоны хувьд ямар утгатай байв? /26/
4. Ирээдүйдээ ямарваа нэгэн юманд найдах найдлагатай байна гэдэг нь настай хүний хувьд ямар байх вэ?
 - "ХҮЛЭЭЛТ" ба "ИТГЭЛ" гэсэн үгс нь хоорондоо юугаараа төстөй вэ?
 - Симеоны хүлээж байсан Мэсси болон бусад хүмүүсийн хүлээж байсан Мэссиагийн хооронд ямар ялгаа байна вэ? (Суурь ойлгот болон 25-р ишлэлийг унш.)
5. Ядуу айлын тэр нэгэн хүүхдийг Эзэний илгээсэн Христ гэдгийг Симеон яаж таньсан бэ?
 - Анна, Симеон 2-ын харсныг сүмд байсан бусад хүмүүс яагаад хараагүй вэ?

6. Сэдвийг дахин нэг удаа анхааралтай уншаад энэ 2 хөгшин хүн Аврагч Мэссиагаас ямархуу авралыг хүлээж байсан байж болохыг хэлнэ үү? (29, 31,32, 38)
 - Та Есүсээс юуг хамгийн их хүсэж хүлээдэг вэ?
7. "Одоо би санаа амар нүд аньж болох нь" гэж хэлэх нь хүмүүс бидэнд хэр амархан байдаг бэ?
 - Симоены хэлсэн үгийг өөрийн амьдралдаан эрэгцүүлэн бод. Түүний ишлэл 29-30-д хэлсэн зүйлийг та ч мөн хэлж чадах уу?
8. Симеоны хэлсэн үг Мариад хүүхэдийх нь тухай ямар шинэ мэдээлэлийг өгсөн бэ? (30-35)
 - Мариагын зүрх сэтгэлийг сэлэм хэрхэн хэсэгчилсэн бэ? (Хариултыг Библийн өөр хэсэгээс ол.) /30-35/
9. Анна, Симеон 2 Есүстэй дахин хэзээ ч уулзаагүй. Есүстэй уулзсан тэрхүү уулзалт нь Анна, Симеон 2-ын амьдралд ямар өөрчлөлт авчирсан бэ? Өөрчлөгдөөгүй үлдсэн зүйл бий юу?
10. Өнөө үед маш олон хүмүүс эш үзүүлэлт ба сүнслэг бэлэгүүдийг сонирхдог. Аннаг яагаад эш үзүүлэгч хэмэн хэлсэн бэ? (36)

Баярт мэдээ: Хэрвээ та Есүсийг Бурханы үгээр харж чадсан бол та Симоены адил “ишлэл 29-30” гэж хэлж чадна.

4. ЕСҮСИЙН БАГА НАС (Лук 2:40-52)

Суурь ойлголт: Еврей хөвүүд 13 нас хірч байж насанд хүрсэнд тооцогддог ажээ. Есүс 4 эрэгтэй мөн хэдэн эмэгтэй дүүтэй байв. /Матай 13:55-56/ Түүний аав нь мужаан байсан бөгөөд Есүс ч эцгийнхээ мэргэжлийг суралцжээ. Еврэй хүмүүсийн хувьд сүм нь гэм нүгэлийнхаа төлөө өргөл өргөж болох цорын ганц газар байжээ. Түүний оршихуй үргэлж тэнд байх болнл гэж Бурхан өөрөө амалсан билээ.

1. Мариа өсөж буй гэр бүлдээ байнга санаа тавих хэрэгтэй байлаа. Дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэхээр жил бүр явдаг байсан нь Мариагын хувд ямар учиртай байсан гэж та бодож байна вэ?
 - Хоёр долоо хоног аялах энэхүү урт аян замд ямар бэлтгэлүүдийг Мариа хийх хэрэгтэй байдаг байсан бол?
2. Айлын ууган нь болох Есүс хүүгийн өдөр тутмын амьдралыг төсөөл.
 - Эцэг эхийнхээ хамтаар анх удаа Иерусалим орох болсон нь Есүсийн хувьд ямар утгатай байсан бол? (хүүд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?)
3. Хамтдаа гэр лүүгээ буцахгүйгээр тэндээ үлдэнэ гэдгээ Есүс яагаад эцэг эхдээ хэлээгүй байсан бэ?
 - Түүний очиж болох өөр олон гзарууд байсан боловч Есүс яагаад сүмд очихийг хүссэн бэ?

4. 46, 47-р зүйлүүд бидэнд Есүсийн тухай юу сургаж байна вэ?
 - 12-хон настай энэ хөвгүүний хамгийн их сонирхож байсан зүйл нь юу вэ?
5. Хаана байгааг нь эцэг эх нь мэдэхгүй байсанд Есүс яагаад гайхсан бэ?
6. Тэнгэрлэг эцэгтэйгаа байгаа газраа биш харин сүмд очиж уулзах нь Есүст яагаад тийм чухал байсан бэ?
7. 48-р зүйл Мариагийн талаар юу өгүүлж байна вэ?
 - Хүүгээ бараа сураггүй алдчихаад байж байхдаа Мариа юунд найдах ёстой байсан бэ?
8. Хүүгийнхээ хариулахыг сонсоод эцэг эхэд нь юу бодогдсон бол?
 - Энэхүү үйл явдлаар Есүс эцэг эхдээ юу сургахыг хссэн бэ?
9. Уг сэдвийн дагуу бол хэдийд бид эцэг эхийнхээ хүслийг огоорч болох нь вэ?
 - Энэ сэдвээс харахад Бурхан өсвөр үеийнхнээс юу хүсдэг вэ?
 - Энэ сэдвийн дагуу бид өсвөр үеийхэнтэй хэрхэн харьцах ёстой вэ?
10. Энэ үйл явдлаас хойш ажлаа эхлэх хүртэлх 18 жилийн турш Есүсийн ээж аавтайгаа болон бусадтай харьцах харьцаа нь ямар байсан бол?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс сүмийг яагаад хайрлах болсон учир шалтгаан Иоханы 2:19-21-д бий. Удирдагч уншиж өгнө үү.

5. ИОХАН БАПТИСТ (Лук 3:1-20)

Суурь ойлголт: Иоханы эцэг эх нь настай хүмүүс байжээ. Энэ үед тэд нас барцгаачихсан байлаа. Иохан гэрлээгүй байсан бөгөөд хамаатан садан гэх хэнч үгүй, ганцаар цөлд амьдарч байв.

1. Эргэн тойронд нь найз нөхөд нь хүрээлэн байдаг байсан бол Иохан ямархуу хүн байх байсан бол?
 - Та маш ихээр ганцаардаж байсан үеэ бодно уу. Ганцаардал таны амьдралд ямар сайн зүйл авчирсан бэ?
2. Иохан өөрөөр нь баптисм хүртээлгэх гэсэн олныг хараад "Хорт могойн удам" гэжээ. /7/ Тэгсэн ч Иохан яагаад Есүсээс илүү нэр алдартай болсон бэ?
3. 7-14 дээрх Иоханы хэлсэн үгийг хар. Энэ ишлэл дээрх үгсийг бид хэрхэн өөрсдийн нийгэмдээ хэрэгжүүлж болох вэ?
 - Энэ үг таны амьдралын ямар шинж тэмдгийг чинь хөндөж байна вэ?
 - Хүн бүр Иоханы хэлсэнчлэн амьдарвал дэлхий ямар байх бол?
4. Иоханы энэ мэдээг цуглаан дээрээ сонсдог бусад мэдээнүүдтэйгээ харьцуулан бодно уу? Ялгаатай зүйл юу байна вэ?

- Цуглааныхны чинь хэн нэг нь Иохан шиг тунхаглавал бусад нь хэрхэн хүлээж авна байх гэж та бодож байна вэ?
5. 4-5-р ишлэл дээр Иоханы үүрэг даалгвар нь хүмүүсийн зүрх сэтгэлд Мэссийгийн замыг бэлдэх нь байсан гэж хэлж байна. Иоханых шиг иймэрхүү хатуу чанд сургаал нь бидний зүрх сэтгэлд Есүс рүү хүрэх замыг хэрхэн бэлтгэдэг вэ?
 6. Ирээдүйд ирэх Мэссиа болон Иохан 2-ын хоорондох харьцаа ямар байсан бэ? /15-17/
 - Иохан яагаад нэр алдраа өөрийн ашигийн төлөө хэрэглээгүй харин даруу байсан бэ?
 7. Хэред захирагчийг хувийн амьдралдаа гэм хийсэн хэмээн Иохан буруушаажээ. /19-20/ Юунаас болж Иохан хааны хувийн амьдралд хөндлөнгөөс оролцох болсон бэ?
 - Бид ямар үед бусад хүмүүсийг завхайрлын гэм нүгэлээс болж буруушааж болох вэ?
 8. Иохан шоронд цаазаар авахуулахдаа 30-хан настай байсан. Түүний энэ богинохон амьдралын утга учир юу байсан бэ?
 - Иоханы амьдралынх нь туйлын баяр баясгалан нь юу байсан байж болох бэ?
 9. Есүс ч Иоханы үгийг сонсогчдын дунд зогсож байсан. Тэрээр сайн үр жимс ургуулагч цорын ганц мод нь байсан атлаа яагаад цавчигдан галд хаягдсан бэ? /9/

Баярт мэдээ: Иоханы энэ мэдээ нь гол төлөв тушаал болоод сануулгаас бүрджээ. Энэ нь хүмүүсийг өөрсдийн гэм нүгэлийн талаар бодоход хүргэжээ. Түүний хэлсэн өөр нэгэн алдарт үг бол "Харагтун, дэлхийн нүглийг үүрэгч Бурханы хурга" буюу Иоханы 1:29 юм. Өөр сайн мэдээний номонд Иохан Мэссиа бидний гэм нүгэлийг хэрхэн шийдэх талаар хэлсэн байдаг.

6. САТАН ЕСҮСИЙГ СОРЬСОН НЬ (Лук 4:1-13)

СУУРЬ ОЙЛГОЛТ: "Уруу татлага" болон "зовлон" гэсэн 2 үг нь Грек эх хэл дээрээ ижил утгатай үгс ажээ. Адам, Евагийн үеэс эхлээд л бүхий л хүн төрөлхтөн сорилтонд тавигджээ. Тиймээс Есүс ч мөн хүний ёсоор соригдох болсон юм.

1. Бүтэн сар хагас хэлэн дээрээ юу ч тавилгүйгээр цөлд цор ганцаар байх хүнийг төсөөл дөө. Ийм нөхцөлд түүний хувьд хамгийн хэцүү зүйл нь юу байж болох вэ?
2. Ямар нөхцөлд гэм хийх сорилтонд илүү их татагдаж байгаа мэт танд санагддаг вэ? /Дотроо хариулж болно./

- Есүсийн сорилтыг өөрийнхтэйгөө харьцуулна уу. Ямар ялгаа байна вэ?
3. Хүмүүсийн гол чухал хэрэгцээ болох хоол хүнс болоод аюулгүй байдлыг нь хөндөн Есүсийг сорьжээ. Хэрэв Есүс чулууг талх болгон хувиргасан бол яаж буруудах байв?
 - Зайлшгүй шаардлагатай зүйлсээр дутагдаж гачигдсан үеийг Буг хэрхэн ашиглаж биднийг уруу татан сорьдог вэ?
 4. Матайн бичсэн өгүүллэгт "... харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг" гэсэн үг байдаг. /Матай 4:4/ Үндсэн хэрэгцээ маань хангагдаагүй нөхцөлд Бурханы амнаас гарах үгээр амьдардаг гэдэг нь хэр боломжтой вэ?
 - Сорилтыг даван туулахад чинь Бурханы үг тусалсан тохиолдол бий юу? Энэ тухайгаа ярина уу?
 5. Хоёр дахь удаад Есүсийг эзэмшил болоод нэр алдар амлан сорьжээ. Хэрвээ Есүс Сатанд мөргөсөн бол хэддэх хууль нь зөрчигдөх байв.
 6. Гурав дахь сорилт нь Библийг хэрхэн тайлбарлахтай холбоотой байв. Хэрэв Есүс дуганы хамгийн өндөр оройгоос үсэрсэн бол тэр юу хожих байв.
 - Бурхан Энээ соривол юу болох вэ?
 7. Энэ 3 сорилтын алинаар нь Сатан таныг илүүтэйгээр сорьдог вэ?
 8. Энэ сэдвийн дагуу бол Сатантай бид яаж тулалдах хэрэгтэй вэ?
 - Сүнсний тулалдааны тухай уг сэдэв бидэнд юу сургаж байна вэ?
 9. Есүс яагаад соригдох ёстой байсан бэ? /Еврей 4:15-16/ -г удирдагч унш.
 - Бид яагаад соригдох ёстой байдаг вэ?
 10. Энэ бүх уруу татлагын сорилтуудыг Есүс дийлж гарсан. Гэтэл яагаад энэ бүхнийг дийлж гарч чадаагүйчүүдийн шийтгэлийг Есүс авсан бэ?

7. ГАЙХАМШИГТ ЗАГАСЧЛАЛ (Лук 5:1-11)

Суурь ойлголт: Петр хадам эхтэй байжээ. /4:38-39/ Энэ нь тэрээр эхнэр хүүхэдтэй байжээ гэдгийг илтгэнэ. Петр загасчин хүн бөгөөд хэрвээ тэр загасчлаад гар хоосон гэртээ ирвэл гэрийнхэн нь амь зогоох юмгүй хэцүүддэг байсан бизээ. Энэ удаад тэд Геннсарет нуранд шөнөжин Нэг ч их гүнзгий бус усанд тороо хаяж загасчилжээ.

1. Шөнийн ээлжинд ажиллаж үзсэн хүн байна уу? Шөнөжин ажилласны чинь дараах өглөө нь ямархуу байдаг тухайгаа ярина уу?
 - Шөнөжингөө хий дэмий хөдөлмөрөө гарздсныхаа дараагаар тороо угаан сууж байхдаа Петр юу бодож байсан бол? (2)
2. Есүс яагаад сургаалаа завин дээрээс заахыг хүссэн бэ? (3)
 - Есүс яагаад заавал Петрийн завийг сонгосон гэж бодож байна вэ?
3. Петр дөнгөж л тороо угаачихаад сууж байсан бөгөөд тэрээр үнэхээр туршлагатай загасчин байсан юм. Харин Есүс загас барих ямар ч туршлагагүй

байв. Гэтэл ямар учраас Петр бусад загасчдынхаа улаан нүүрэн дээр ямар ч туршлагагүй Есүсийн үгэнд орж аз турших болов? (4-5)

- Петр загас баригдана гэдэгт итгэлтэй байсан болов уу эсвэл үгүй болов уу?
4. Хэрвээ Есүс таны ямар ч боломжгүй хэмээн бодож байсан зүйлийг чинь хийлгэх гэвэл та юу гэж хариулах вэ?
 5. Хэдэн жилийн өмнө Есүсийн амьдарч байсан үеийн нэгэн завийг Геннесарет нуурны шавар дотроос олжээ. Тэр нь 8 метр урттай, 2-3 метрийн өргөнтэй байсан байна. Яг ийм хэмжээ бүхий 2 завийг тус бүр нь 1 кг жинтэй загаснуудаар дүүргэвэл хэдий хэмжээний загас орох бол? (7)
 - Энэ их загаснуудыг яасан бол?
 6. Энэ гайхамшигийг үзээд Петрийн хариу үйлдлийн юу нь таны гайхшарлыг төрүүлж байна вэ?
 - 8-р зүйл дээрх эдгээр үгсийг хэлж байхдаа Петр ямар гэмүүдийн тухай бодож байсан бэ?
 7. Энэ гайхамшиг Петрт Есүсийн тухай юу сургасан бэ? (5; 8-р зүйлүүд дээр тэр Есүсийг хэрхэн нэрлэснийг үз)
 - Юу түүнийг айлгасан бэ?
 8. Яагаад Есүс Петрийг гэмшсний дараагаар 10-р ишлэл дээрх үгээ хэлэх болов?
 - Загасчин хүн ба авралын зарыг тунхаглагч хоёрюугаараа адил байдаг вэ?
 9. Гэр бүлээ орхин, Есүсийг даган явахад нь ар гэрийнхэн нь өлбөрч үхэхгүй гэх ямар баталгаа Петрт байсан бэ?
 - Хэрэв та Есүсийг дагахаар нэгэнт шийдсэн бол, гэр бүлийнхэн чинь зовж шаналахгүй байх болно гэсэн баталгаа танд бий юу?

Баярт мэдээ: Ариун Эзэний дэргэд гэмт хүн ойртож болохгүй гэж бодсноороо Петр андуураагүй юм. Тэрээр хуучин гэрээ номонд "Гэмт хүн Ертөнцийн Эзэнд ойртвол үхэх болно" хэмээн бичигдсэн байдгийг мэддэг байжээ. Тиймээс Есүс Петрийн айж байсан айдсыг туулах ёстой байсан юм. Түүнийг үхэлтэй тулгараад байх үед нь Бурхан орхисон байжээ.

8. ХЭН НЬ ХАМГИЙН ЖАРГАЛТАЙ ВЭ? (Лук 6:20-26)

Суурь ойлголт: "Ивээгдсэн" гэдэг нь Грекээр "туйлын жаргалтай" гэсэн үг юм. Энэ сэдэвт гарч байгаа "баян" хүмүүс нь амьдралдаа хүсэж байсан бүхнийгээ авсан: мөнгө, хайр мөн эрүүл мэнд. "Ядуу" гэсэн хүмүүс нь эдгээр зүйлүүдийг хэзээ ч аваагүй эсвэл авсан байж байгаад алдсан хүмүүс юм. (Ядуу гэсэн үгийг "сүнсээр ядуу" гэж ойлгож болохгүй. Есүс тийм утгаар хэлээгүй.)

1. Энэ сэдвийн дагуу хүний жинхэнэ аз жаргал гэж юу вэ?
 - Харин аз жаргалгүй байх гэдэг нь юу вэ?
2. Есүсийн хэлсэнээр бол ядуу байхын ашигтай тал нь юу вэ? (Суурь ойлголтоос "ядуу" гэсэн үгний тайлбарлыг хар)
 - Мөн энэ утгаараа баян байхын сөрөг тал нь юу вэ?

- Энэ 2 ангилалын алинд нь та багтах вэ? (Та үүнийг дотроо хариулж болно.)
3. Манай нийгэмд идэх хоолгүйгээс болж өлсөж байдаг олон хүмүүс байдаг. Ийм хүмүүсийг Есүс хэрхэн аз жаргалтай гэж хэлж чадах вэ?
 - Манай нийгмийн олон хүмүүс хайр ба хүндэтгэлээр дутагдаж байдаг. Тэрхүү хүмүүсийг Есүс яаж аз жаргалтай гэж хэлж чадаж байна вэ?
 4. Танд үнэхээр хүнд хэцүү байсан үеэ бодно уу? Яг тэр үед Есүс хажууд чинь ирээд "Гашуудан уйлагч чи үнэхээр ерөөлтэй ээ" гэж хэлбэл танд ямар санагдах вэ?
 - Огт уйлдаггүй хүнийг төсөөл дөө. Тэр хүнийг жаргалтай хүн гэж нэрлэж болохгүйн учир юу вэ?
 5. Гашуудан уйлж буй дагалдагчдаа та нар ерөөлтэй ээ хэмээн Есүс яаж хэлж чадаж байна вэ?
 - Уйлж буй дагалдагчид нь уйлж байх үедээ жаргалтай байх юм уу эсвэл хожим инээх үед ээ юү?
 6. Баян, цатгалан, хангалуун, үргэлж инээгч хүмүүсийг сайн хүмүүс гэж нэрлэж болохгүйн учир юу вэ?
 - Эдгээр хүмүүсийн уйлах цаг хэдийд ирэх вэ?
 7. Хараагдаж шүүмжлүүлсэн ч гэсэн баяр жаргалаар дүүрэн байдаг хүмүүс байдаг гэж та бодож байна уу? Хэрвээ тийм бол тэр хүмүүс яагаад йинхүү үйлдэж чаддаг вэ?
 8. Буруу эш үзүүлэгчид сайнаар магтагдаж харин үнэнийг яригчийг үзэн ядадгын учир нь юу вэ? (22:26)
 9. Есүс яагаад дэлхий дээрхи бүх зовж буй хүмүүсийг ерөөлтэй хүмүүс гэлгүй зөвхөн дагалдагчдаа л тийнхүү нэрлэсэн бэ? (20)
 10. Эдгээр зүйлүүдийг Есүсийн амьдрал руу хандуулъя. Дараах зүйлсийг хэлэлцэнэ үү: Загалмайн зовлонг амсахдаа Есүс туйлын жаргалтай байсан уу? Тийм бол яагаад? Үгүй бол мөн яагаад?
 - Есүсийг зовж тарчилж байхад Бурхан яагаад дэмжлэг өгөөгүй юм бол?

9. ӨСТНӨӨ Ч ХАЙРЛА (Лук 6:27-38)

Суурь ойлголт: Энэхүү сэдвийг уншиж байх зуураа өнгөрсөн 7 хоногт болсон зүйлээ мөн тэр үед эдгээр хуулиуд хэрхэн мөрдөгдөж байсаныг бодоорой.

27-30-Р ЗҮЙЛ:

1. Есүсийн ийнхүү сургасны дагуу амьдрах нь зүйтэй хэмээн бараг бүх хүн л хүлээн зөвшөөрөх биз ээ. Гэвч тийнхүү амьдрахад яагаад хэцүү байдаг вэ?
 - Хэрэв Есүс зүгээр л "Өстөн дайснууддаа элэгсэг ханд" гэж хэлсэн бол түүний сургаалыг дагах нь илүү хялбар байх байсан болов уу?
2. Та гэр бүл, сургууль, ажил албаныханыхаа дотор энэхүү хуулийг мөрдөж эхэллээ гэж боддоо. Тэгвэл гэр орон, ажил сургууль дээр юу өөрчлөгдөх бол?
 - Дургүй хүнийхээ төлөө залбиран гуйлаа гэхэд хоорондын харилцаа сайжирна гэж та бодож байна уу? /28 б/
3. Есүс энэ бix хуулиудыг сахиж чаддаг байсан юм. Тэгсэн ч түүнд яагаад ийм олон дайснууд байсан гэж та бодож байна вэ?
4. Үзэн ядалт, өш хонзон нь ямар хор уршигтай вэ?

31-38-Р ЗҮЙЛ:

5. Сэдэвт гарч буй "Хамгийн Дээд Нэгэний хөвгүүд" болон нүгэлтнүүд" ийн хоорондын гол үндсэн ялгаа нь юу вэ?
 - Ямар утгаараа та нар "Хамгийн Дээд Нэгэний хөвгүүд"-ийг төлөөлж мөн ямар утгаараа "Нүгэлтэн "-үүдийг төлөөлдөг вэ?
6. Өрөөл бусдыг болохоор биднийг халамжилж анхаарсангүй хэмээн гомдоллогчид хир эндүүрч байна вэ? /36-38/
 - Ямар хүмүүс бүхнээс илүүтэйгээр, хэмжээлшгүй их хайраар хайрлуулахыг хүсдэг вэ?
7. 35-р зүйл дээр Есүс биднийг өөрийх нь дайснууд байхад ч хайрлаж байсан тэр хайрын тухай үгүүлж байна. Уг ишлэлийг уншаад дараах асуултанд хариулна уу? Хүн төрөлхтөний хувьд үлэмжийн хэмжээлшгүй их хайр байдаг гэдэгт итгэхэд хир хэцүү вэ?
8. Энэ хуулийг сахиж чадсан хэн бүхэнд агуу шагнал амлажээ. Гэвч Есүс энэ хуулийг сахиж чадсан хирнээ шагнал авах бус харин цовдлогдон шийтгэгдсэн. Яагаад вэ?
9. Бид хэрхэн дайснаа хайрлаж сурах вэ?
 - Дайснаа хайрлаж чаддаггүй хүмүүс яаж "Хамгийн Дээд нэгэний хөвгүүн" болох вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Жинхэнэ утгаараа "Хамгийн Дээд Нэгэний хөвгүүн" бол ганцхан ЕСҮС л байсан. Тэр дайснаа ч өрөвдөн хайрлаж, шийтгүүлэн нас барахдаа ч тэдний төлөө залбирч байсан. ЕСҮС өөрөө шагнал горьдсонгүй, харин өөрөөс нь уучлалыг хүссэн, хуулийг дагаж үл чадагч хүн бүрт тэр энэ шагналыг өгөх юм.

10. ЧИНИЙ АМЬДРАЛЫН ҮНДЭС СУУРЬ (Лук 6:46-49)

1. Ишлэл 45 дээр Есүс хэний тухай ярьж байна вэ?
2. Байшин болон хүний амьдрал 2-ын ижил төстэй талууд нь юу вэ? Төсөөтэй байж болох бүх л шинжийг нь хэлнэ үү.
 - Яагаад ихэнхи хүмүүс байшингийн (амьдралын) суурийг нь биш харин гаднах өнгө үзэмжийг нь илүү чухал гэж үздэг вэ?
3. Хүмүүс ямар зүйлүүдийг амьдралынхаа үндэс суурь болгож болох вэ?
 - Ихэнхи хүмүүс яагаад түшиж тулах үндэс суурь тавилгүйгээр амьдралаа зохиодог вэ?
4. Хүний амьдралд тохиолдож болох “үер” болон “усаар” Есүс юуг илэрхийлсэн бэ?
 - Нэг л өдөр таны түгшиж явдаг тэрхүү үер ус амьдралд чинь сад тавин орж ирвэл та хэрхэн давж гарах вэ?
5. Энэ сургаалт зүйрлэлийн дагуу бол "ҮЕР УС" нь Христэд итгэгчдийн ч тэр, үл итгэгчдийн ч тэр аль алины нь амьдралд ялгаагүй л орж ирдэг. Энэхүү аюулаас Христ Итгэгчдийг яагаад хэлтрүүлж болоогүй юм болоо?
6. Таны амьдралд тохиолдож байсан аюул гамшигын тухай бодно уу. Та тэр үед юунд байдаж байсан бэ?
 - Амьдралын тэр хэцүү үед Есүсийн үг таньд хэрхэн тусалсан тухай хуваалцна уу.
7. Үерт байшин нь сүйрсэн хүн яах вэ? (Энэ аюул ослын дараагаар тэд ямар амьдралаар амьдрах вэ?)
8. Есүсийн үгийг нь сонсчихоод үл биелүүлдгийн учир нь юу вэ?
 - Сонссон үгийг үйл хэрэг болгоход нөлөөлөх хүчин зүйл нь юу байх вэ?
 - Үгийг нь сонсоод биелүүлэгч, үл биелүүлэгч 2-ын аль бүлэгт нь та багтах вэ? (Та зүрх сэтгэлдээ хариулж болно.)
9. Үгийг үйл хэрэг болгоно гэдэг нь хамгийн сүүлд бидний ярьснаар "Дайснаа ч өрөвдөн хайрла" гэдэгтэй ч мөн холбоотой билээ. Амьдралын минь суурь бол "Дайснаа өрөвдөн хайрлах" - юмаа гэж та хэлж чадах уу?
10. Библи дээрх "Хад" гэдэг үг нь өөр нэг утгыг илэрхийлдэг. "Тэр хад бол Христ байлаа" хэмээн Паулын хэлсэн үг 1 Кор10:4-т байдаг. Амьдралаа Есүсийн хуулиуд дээр суурилуулах аль эсвэл Христ өөр дээр нь / Баярын мэдээ / суурилуулах 2 юугаараа ялгаатай вэ?

11. Есүс өөрөө энэ бүх хууль дүрмүүдийг сахиж байсан. Гэтэл яагаад түүний байшинг энэ ҮЕР УС мөн дайрч гарсан бэ?

11. НАЙН ХОТЫН БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙ (Лук 7:11-17)

Суурь ойлголт: Хүмүүс яагаад Есүсийг агуу зөнч гэж нэрлэж байсан юм бэ гэвэл тэд Элигаах, Элиза нар нэгэн бэлэвсэн эмэгтэйн хүүг хэрхэн амь оруулсан тухай санаж байсантай холбоотой ажээ. /16/

1. Энэ оршуулганд яагаад тийм олон хүн оролцохыг хүссэн байж болох вэ? /12/
Бололцоотой бүх шалтгаануудыг тооцно уу.
2. Энэ бэлэвсэн эмэгтэйн амьдрал ямархуу байсан тухай бодно уу? Аль болох олон хүүхэдтэй болохыг хүн бүр хүсэж байхад энэ эмэгтэй зөвхөн ганц л хүүхэдтэй байжээ. Эцэг нь нас бараагүй байх үеийн энэ цөөхөн ам бүлтэй айлын амьдралынх нь баяр баясгалан нь юу байсан бэ?
 - Нөхөр нь нас барах үед энэ эмэгтэйд юу хамгийн хэцүү мэт санагдсан бол?
3. Ганц хүүгээ өсгөж өндийлгөхөд эхэд нь ямар санхүү болон сэтгэл санааны хэцүү асуудлууд тулгарч байсан бол?
4. Хүүгийнхээ шарилын араас дагаж явах үедээ мөн тэр Их Эзэний та лаар юу бодож явсан бол?
5. Залуу хүүг нас барах үед Есүс Найн хотоос 40 км-ийн зай орших Капернаум хотод байсан байжээ. /7:1/ Оршуулга оройтлоо гэхэд л нас барсны дараах өдөр нь байв. Есүс яагаад энэ их хол замыг туулан ирж оршуулганд оролцохыг хүссэн бэ?
 - Тусламж гуйж ирээгүй байхад яагаад Есүс өөрөө тэр бэлэвсэн эмэгтэйд туслахыг хүссэн бэ?
6. Танд ер нь Бурхан цагт нь амжиж туслаж чадахгүй бол яанаа хэмээн түгшиж байсан удаа бий юу? Хэдийд вэ?
 - Есүсийн тусламж хэзээ ч хоцорч ирдэггүйд бид хэрхэн итгэлтэй байж болох вэ?
7. Есүс үйлж буй эхэд яагаад "Бүү үйл" гэж хэлсэн бэ?
 - Таныг ч мөн "Бүү үйл" хэмээн Есүс хэлж байна. Тэр үүгээр юу хэлэхийг хүссэн бэ?
8. Есүс залууг үхлээс яаж дахин амилуулсан бэ?
 - "Есүс залууг эхэд нь эргүүлэн өгөв" /15/ гэсэн нь ямар утгатай вэ?
9. Энэ үйл явдлаас хойш эх, хүү 2-ын харилцаанд мар өөрчлөлт гарсан бол?
10. Тэнгэрлэг эцэг маань ч мөн өөрийнх нь цорын ганц хүүг булш руу нь аваачихыг харсан. Түүний үй гашуу тэр бэлэвсэн эмэгтэйн үй гашуугаас илүү байсан болов уу эсвэл бага байсан болов уу?
 - 16-р зүйл дээр "Бурхан өөрсдийн хүмүүс дээр туслахаар ирлээ" гэжээ. Тэр яагаад өөрийнхөө хүүг үхэж байхад нь туслахаар ирээгүй вэ?

12. УУЧЛАЛЫГ АВСАН ЭМЭГТЭЙ (Лук 7:36-50)

Суурь ойлголт: Энэ үед эмэгтэй хүн олоны дунд үс толгойгоо ил харуулдаггүй байжээ. 44-46-р зүйлүүд дээр хүндтэй зочдыг тэр үед хэрхэн хүлээж авч зочилдог байсан тухай өгүүлжээ.

1. Есүсийг гэртээ урьсан Фарисай хүн Есүсийн талаар ямар бодолтой байсан бэ? /36, 39, 44-46/

- Симон Есүсийг яагаад хамгийн түрүүнд урьсан болоо?
2. Симоны гэрт ирсэн тэр эмэгтэйг бүх хүмүүс тэддэг байжээ. Учир нь эмэгтэй тэр хлтын биу үнэлэгч байв. /37/ Энэ эмэгтэйн хүүхэд ахуй үеийнх нь амьдрал ямархуу байсан бол? Юунаас болж тэр эмэгтэй ийм шившигтэй амьдралаар амьдрах болов?
 - Энэ эмэгтэй ямар хайр халамжийг амьдралдаа мэдэрсэн бол?
 3. Гөлтөгнөн савтай үнэт тос тэр үед их үнэтэй байжээ. Ямар учраас тэр эмэгтэй их мөнгө цуглуулж үнэт тосыг худалдаж авсан гэж та бодож байна вэ?
 4. Фарисай хүний гэрт очвол таатай уур амьсгал өөрийг нь угтаж авахгүйг мэдэж байсан хирнээ эмэгтэй яагаад заавал тэнд Есүстэй уулзах ёстой байсан бэ?
 - Есүс өөрийг нь цааш түлхэхгүй гэдэгт эмэгтэй итгэлтэй байсаны учир юу вэ?
 5. Эмэгтэй яагаад Есүсийн биед хүрэхийг хүссун бэ?
 - Дургүйцлийг чинь төрүүлдэг хүн чиний биед хүрвэл яах вэ?
 - Эмэгтэйг Есүсийн биед хүрэхэд юу болсон бэ?
 6. Эмэгтэй яагаад Есүсийн хөлийг нортол тийм их уйлсан бэ?
 7. Энэ эмэгтэйн хувьд Есүст итгэх итгэл, Есүсийг хайрлах хайр 2-ын аль нь эхэлж төрсөн бэ? /Хариуг сэдвээс гаргаж ирнэ үү/
 - Та хэзээ нэгэн цагт Есүст үнэхээр их хайртай гэдгээ мэдэрч байсан байх. Тэгвэл яг ямар учраас болж танд тийм сэтгэл төрсөн гэж та бодож байна вэ?
 8. 41; 42 дээр Есүс мөнгө зээлдүүлэгчийн тухай бяцхан сургаалт зүйрлэл ярьжээ. /500 денар нь 12 жилийн ажлын хөлстэй тэнцэх мөнгө бөгөөд 50 денар нь 12 сарын ажлын хөлстэй тэнцэх юм./ Энд Есүс гэм нүгэлийг өртөй төсөөлсөн байна. Энэ сургаалт зүйрлэлээр Есүс Симонд юу сургахыг хүссэн бэ?
 - Симоны ямар гэмийг Есүс жишиж хэлсэн бэ?
 9. Эмэгтэйн Бурханд гэм нүгэлийн өртэй байсан тэр өр нь юу болон бэ?
 - Симоны Бурханд өртөй байсан гэмийн өр нь юу болсон бэ?
 - Симон яагаад Есүсийг хайрлаагүй вэ?
 10. Бүх л гэмийг чинь ил харагч Есүс танд ийнхүү хэлж байна. /48;50/ Та ямар хариулт өгөх вэ?

13. ТАРИАЧНЫ ТУХАЙ СУРГААЛТ ҮЛГЭР (Лук 8:4-15)

Суурь ойлголт: Тариачны тухай сургаалт үлгэр нь Есүсийн ярьсан хамгийн эхний сургаалт зүйрлэл байсан юм.

1. Есүс Бурханы үгийг үр тариатай зүйрлүүлсэн нь ямар учиртай вэ? Аль болох олон адил талуудыг ол.
 - Энэ сургаалт зүйрлэлээр Есүс өөрийнхөө хийх ажлын талаар юу бидэнд хэлэхийг хүссэн бэ?
2. Ямар замаар муу сүнс Бурханы үгийг бидний зүрхнээс булаан авдаг вэ? (5, 12)
 - 12-р зүйлд бичигдсэн шиг зүйлийг үзэхгүйн тулд бид юу хийх ёстой вэ?
3. 6 болон 13-р ишлэлүүдийг хар. Хэн нэгнээс Христийн итгэлийг алдруулах ямархуу сорилтууд байж болох вэ?

- 13-р ишлэл дээрх хүмүүс эхлээд юунд баярлаж байсан бол?
 - Есүсийн "үндэс суурьгүй христчин хүн" гэсэн нь ямар утгатай вэ?
4. Амьдралын зовнил, эд баялаг, амьдралдаа сэтгэл ханах зэрэг зүйлс нь яагаад Бурханы үгийг мөхөөдөг вэ? /7, 14/
 - Хрисчин хүний хувьд баян хангалуун байдал нь яагаад хомс тарчигхан байдлаас илүү аюултай байдаг вэ?
 - Амьдралын зовнил, эд баялаг, хангалуун байдал зэрэг зүйлс нь биднийг бага багаар Бурханы үгээс холдуулж байгааг гэнэт мэдвэл бид юу хийр ёстой вэ?
 5. Мүү хөрсийг яаж сайн болгох вэ? /8, 15/
 - Ямар нөхцөлд хүний амьдрал үр жимсээр баялаг өгөөжтэй байж болох вэ?
 6. Яг энэ цаг мөчид таны зүрх сэтгэл энэ 4 хөрсийн алинтай нь адил байна вэ? (Та дотроо хариулж болно.)
 7. Зуу дахин илүү ургац өгнө гэсэн нь юу гэсэн утгатай вэ? (8)
 - Өнөө үеийн итгэгч нар өөрсдийн тариалангаас нэг л шөнийн дотор ургацыг хүлээдэгийн учир нь юу вэ?
 8. Сургаалт зүйрлэл нь Авралын зарын талаар бидэнд юу сургаж байна вэ?
 9. Библи дээр Есүсийг Бурханы үгтэй зүйрлүүлж бичсэн байдаг. (ахлагч нь Иохан 1:1-ийг уншиж өгнө үү.) Есүс, үртэй юугаараа адил төстэй вэ?

БАЯРТ МЭДЭЭ: ЕСҮС дэлхий дээр байх хамгийн сүүлчийн шөнөө ийнхүү хэлжээ. "Хүний хүүгийн алдарших цаг нь ирлээ. Үнэнээр үнэнээр би та нарт хэлнэ. Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвэл олон үр бий болно" /Иохан 12:23-24/ Ийнхүү хэлсэнчлэн тариачны тухай сургаал дахь үр тариа нь Библийн дэмий ч нэг үг биш, харин загалмайн тухай өгүүлдэг ажээ.

14. БИ ТАНЫГ ДАГАЯ. (Лук 9:57-62)

1. Энэ сэдэвт Есүсийг дагахын үнэ цэнийг тооцон буй 3 хүний талаар өгүүлжээ. Та ийнхүү тооцож байсан удаа бий юу? Хэдийд, яагаад тэгсэн бэ?
2. Эхний хүнд Есүс яагаад зүгээр л "Намайг дагаад яв" гэж хэлээгүй вэ? /57-58/
 - 58-р зүйлээс харахад Есүс тэр хүнд чухам юу хэлэхийг хүсч байсан бэ?
3. 58 дээр өгүүлсэнтэй адил амьдралыг Есүс танд амлавал та хэрхэн хүлээж авах вэ?
 - Есүс Ертөнцийн Эзэний хүү байтлаа яагаад 58-р ишлэл дээр өгүүлсэн тэрхүү амьдралаар амьдрах болсон бэ?
4. Хоёрдахь хүний хамгийн эрхэм зүйл нь юу байв? /59-60/
 - Энэ хүний эрхэмлэдэг зүйлсийг өөрийнхтөйгөө харьцуулна уу?
 - Хүүхдүүд чинь ийм үед юуг эрхэмлэдэг байгаасай гэж та боддог вэ?
5. Гэрийнхнээс нь хэн нэг нь нас барсан тохиолдол нь биднийг яагаад Есүсийг дагаж явж чадахгүй мэт бодогдуулдаг вэ?
6. Гуравдахь хүн гэрийнхэнтэйгээ дахин нэг уулзчихаад ирье гэсэн шалгаан нь юу вэ? /61-62/
 - Энэ хүний өчүүхэн хүсэлтийг Есүс яагаад хүлээж авсангүй вэ?
7. Хэрэв энэ гурван хүн Есүсийг дагаагүй байсан бол тэдний амьдрал ямар байх байсан бол? Бурханы хаанчлалыг тунхаглах замыг сонгосон бол тэдний амьдрал ямар байх вэ?

8. "Эцэг эхээ хүндэлж бай" хэмээн бараг бүх л ард түмэн мөн Есүсийн үед ч хүүхдүүддээ ярьж сургаж ёс заншил болгон хүмүүжүүлсэн байдаг. Есүс яагаад энэ ёс заншлыг зөрчих болов?
 - Есүс ч мөн "Эцэг эхээ хиндлэх" нь хэр чухал тухай зааж байсан. Энэ сэдвийг дөрөв дэх хуультай хэрхэн нийцүүлж чадах вэ?
9. Есүсийг дагах нь хэр хэцүүг өнөө үед ч гэсэн Есүсийн энэ 3 хүнд сануулж байгаатай адил залуу хүмүүсд сануулдаг болов уу?
10. Бурханы хаанчлалд үйлчлэх нь танд зохихгүйг та мэдвэл яах ёстой вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс Иерусалим орох замдаа эдгээр зүйлсийг ярьжээ. Тэрээр өөрөө анжсан дээр гараа тавиад эргэж харалгүйгээр зөвхөн үүрэх зовлонгийнхоо өөдөөс эргэлт буцалтгүй алхсан юм. Бурханы хаанчлалд тэнцсэн нь цорын ганц ЕСҮС билээ. Тэр өөрийнхөө төлөө бус харин бидний төлөө тэнцсэн юм.

15. Тэнгэр дахь нэр (Лук 10: 17-20)

Суурь ойлголт: 1 болон 9-р ишлэлүүдийг унш.

1. Өнөө үеийн сүм цуглаанд явдаг хүмүүс энэхүү 70 хүний адил хүч чадалтай байсан бол юу болох байсан гэж та бодож байна вэ?
 - Энэ 70 хүмүүс яагаад үйлчлэлийнхаа зөвхөн нэг хэсэгийг л дурьдсан бэ?
2. Хүмүүс яагаад эрх мэдэл хүч чадалтай болчихоод баяарлан хөөрөлддөг вэ?
 - Дагалдагч нар нь амжилтанд хүрсэн гэж баяралдан хөөрөлдөж байхад Есүс яагаад тэдэнтэй баярлаагүй вэ?
1. Хэн нэгэний үйлчлэлийн амжилтны төлөө баярлах ба гэнгэрт нэр нь бичэгдэсний төлөө баярлах нь юугаараа ялгаатай вэ?
 - Энэ дэлхий дээрх зүйлсээс болж баярлдаг нь яагаад тэнгэрт байгаа зүйлсэд баярлахаас илүү амархан байдаг вэ?
2. Муу сүнсийг зайлуулдаг хүчиндээ баярлдаг дагалдагч юу гэж тунхаглах вэ?
 - Тэнгэрт нэр нь бичигдсэнд баярлдаг дагалдагч хүн юу гэж тунхаглах вэ?
1. Бидний хэг тэнгэрт бичигдсэн гэдэгт баярлахын тулд эхлээд юу болох ёстой вэ?
2. Хэзээ мөн хэрхэн бидний нэр тэнгэрт бичигдэх боломжтой вэ?
3. 19-р ишлэл дээр хэлсэн зүйлтэй адил зүйлүүд та хаана хэзээ сонсож байсан бэ?
 - Ямар үед тэ могой болон хэлэнцэн дээр гишгэх зориг гаргадаг вэ?
1. Яагаад юу ч хэн ч Есүсийн дагалдагч нарт хор хөнөөл учруулж чадахгүй вэ?
 - Юу таныг болон таны хайртай хүмүүсд хор хөнөөл учрууна гэдгээс та айдаг вэ?
 - Энэ сэдэвийн дагуу бол бид юунаас айх хэрэггүй вэ?
 - Харин бидний айх ёстой зүйл юу вэ?
2. Есүсийн дагалдагчидын ихэнх нь тамлагдан алуулсан билээ. Гэвч тэд өстөн дайснуудынхаа эрх мэдлийг ялан дийлсэн гэдэг нь ямар утгаараа үнэн вэ?

- Муу сүнс Есүсийг загалмай дээр байхад улыг нь няцлах зөвшөөрөлтэй байсаны учир юу вэ?

1. Энэ сэдэв нь бидний үйлчлэлийн талаар юу г хэлж байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Библи бидэнд тэнгэрт нэр нь бичигдээгүй хүүмүүсийн хувь тавилангын талаар хэлдэг. (Илчлэлт 20:15) Амийн номонд нэр нь бичигдээгүй хэн ч болов ч галтай нууранд хаяагдах болно. Есүс биднийг ийм аймшигт хувь тавиланг бүү амсаасай гэсэндээ Мосегийн адил (Египтээс гэрсэн нь 32:32) “Хэрвээ одоо та хүсвэл тэдний нүгэлийг уучлаач. Хэрвээ үгүй бол Та Өөрийнхөө бичсэн номноос миний нэрийг арилгаач” хэмээн залбирсан юм.

16. САЙХАН СЭТГЭЛТ САМАРИ ХҮН (Лук 10:25-37)

Суурь ойлголт: Есүсийн амьдарч байсан үеийн Еврейчүүд Самари үндэстнүүдийг цус холилдсон, хагас шүтлэгтэн хэмээн гадуурхан, үзэн яддаг байжээ. Самаричуудын сүм нь Гэризим уулан дээр Иерусалимаас 50км зайтай байдаг байв. Тэд Библээс зөвхөн /Эхлэлээс-Дэд хууль хүртэлх\ Мосегийн таван номыг л хэрэглэдэг байжээ. Энэ сургаалт зүйрлэл дээрх зодуулсан хүн нь еврей хүн байсан бололтой. Хажуугаар нь өнгөрсөн тахилч болон Лэви хүмүүс сүмд очиж өөрсдийн үүргийг гүйцэтгэхээр явж байсан байх. Хэрвээ тэд цусанд хүрсэн байсан бол үлдсэн өдрийн турш ариун бус байж сүмд орох эрхгүй болох байсан.

1. Зодуулсан хүн зам дээр хэдэн цагаар хэвтэж байх үедээ юу бодож байсан бол?
 - Ийнхүү аян замаасаа цагтаа иргэж ирээгүй нөхөригөө хүлээж байхдаа эхнэр хүүхдүүдэд нь ямар байсан бол?
2. Ихээхэн шүтлэгтэй гэгдэх Лэви хүн, тахилч 2 үхэж буй хүнд яагаад туслахыг хүссэнгүй вэ? Олон талаас нь авч үз.
 - Хуулийн шинжээч энэ сургаалт үлгэр дээрх Лэви хүн, тахилч 2-ын зан байдлыг хэрхэн дүгнэсэн бол? /25-27/
3. Өөрсдийн Библээс сайн мэдэх хайрын тухай хуулийг тахилч болон леви хүн хэрхэн хэрэгжүүлсэн бэ? /27/
 - Зовж буй хүнд тэр шүтлэгтэй хүмүүсийн адилаар хандсан атлаа "Би Бурхан Эзэнээ бүх зүрх сэтгэл, бүх хүч чадлаараа, бүх санаа бодлоороо хайрладаг" гэж хэлэх боломжтой юу?
4. Самари хүн зодуулсан хүнд туслахгүй байж болох маш олон шалтгаан байсан. Ямар, ямар шалтгаанууд байж болох вэ?
 - Иймэрхүү нөхцөл байдалд орчихоод байгаа хүнд үзүүлж болох наад захын тусламжууд юу вэ?
 - Зодуулсан хүнд Самари хүн өөр ямар нэмэлт тусламж үзүүлсэн бэ?
5. Хоёрхон өдрийн хөлсөнд 2 мөнгөн зоос үлдээсэн нь нэг хүний бүтэн 2 сарын буудлын хөлстэй тэнцэх мөнгө ажээ. Энэ нь манай ханшаар хир их мөнгө вэ?
 - Самари хүн яагаад өөрийнх нь нутгийнх нь ч биш, огт танихгүй хүний төлөө их хэмжээний мөнгө зарцуулахыг хүссэн бэ?
 - Энэ Самари нүх танихгүй хүнд үйлдсэний адилаар тэ хэнд үйлдэж чадах вэ?
6. Самари хүн "Чи Бурхан Эзэнээ бүх зүрх сэтгэл, сүнс, санаа бодлоороо хайрла" гэсэн хуулийг сахиж чадсан уу? /27/ Яагаад?
7. Тахилч, Лэви хүн 2 шиг найз хөршигөө зовж байгаа үед нь үл тоон, өнгөрсөн явдал чамд бий юу?

- Та айл хөршиддөө туслахын тулд одооноос ямар алхам хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?
8. Есүс, Самари хүн 2-ын ижил төстэй зүйлүүд юу вэ?
 - Есүс өөрийнхөө дайсанүүдэд Самари хүнээс илүү юу хийсэн бэ?
 - Зүрх сэтгэлдээ байнга шархтай байдаг бидний төлөө Есүс юу хийсэн бэ?
 9. Энэхүү нэгэн жишээг сайн хэлэлцэнэ үү. Дэлхийн 2-р дайны үед Еврейчүүд хавчигдан зовж байх тэр үед Европын ихэнхи орнуудын Христэд итгэгчид яагаад туслаагүй вэ? Танай цуглаанд эсвэл сүмд иймэрхүү зүйл тохиолдож байсан үү?

17. ҮНЭНДЭЭ ГАНЦХАН ЮМ Л ХЭРЭГТЭЙ. (Луук 10:38-42)

Суурь ойлголт: Есүсийн үед эмэгтэйчүүдийн нөхцөл байдал одоогийнхоос огт өөр байлаа. Тэд эрчүүдийн хамт сууж библи судлах зав чөлөөгүй их л ажилтай байцгаадаг байжээ.

1. Та сайн найзындаа зочлохдоо тэднээс ямар зүйлийг хүсдэг вэ?
 - Есүс дагалдагчидтайгаа бүхэл өдөржингөө гадуур явсан. Тэгээд энэ эгч дүү хоёрын ирээд юуг бүхнээс илүүгээр хүсч байсан вэ?
2. Есүсийг ирэхэд Марта Мариа 2 хэрхэн хүлээж авсаныг бод. Үүний алийг нь ойлгоход танд хялбар байна вэ? Яагаад?
3. Мартад хэцүү байсан тухай 40-р зүйлд өгүүлжээ. Энэ нь юу байв аа?
 - Марта яагаад зөвхөн дүүдээ бус мөн Есүст бухимдаж байсан вэ?
 - Танд ямар үед "Эзэн, ... Та анзаарахгүй байна уу" хэмээн хэлмээр санагдаж байсан бэ?
4. Оройн зоогны талаар Мариа юу бодож байсан бол?
 - Есүс яагаад Мартааг сургаалыг минь сонсоосой гэж хүсэмжилж байсан вэ?
5. Зарим итгэгчид Их Эзэний үгийг сонсохоос илүү түүний ажилд үйлчлэхийг хүсдэг. Яагаад тэр вэ?
 - Хоёр хүний харилцаан дээр нэг нь нөгөөгөө юу ярьж байгааг сонирхохгүй сонсохгүй байвал энэ юуг харуулж байна вэ?
6. "Үнэндээ ганцхан юм л хэрэгтэй билээ" гэдгээрээ Есүс юу хэлэхийг хүссэн бэ? /42/
 - Амьдрал ба үхэлд хамгын чухал нь Христийн үгийг сонсох гэдэгт та санаа нийлж байна уу?
7. Таныг байнга үгийг минь сонсоосой гэж Есүс хүсдэг нь ямар учиртай вэ?
 - Өнөө үед бид Есүсийн үгийг хаана мөн яаж сонсож болох вэ?
 - Хэрэв бид түүний үгийг хаяа нэг эсвэл тохиолдолоор л сонсдог бол юу болох вэ?
8. Ямарваа нэгэн зүйл хийхээр шийдэх тэр мөчдид өөр нэгэн зүйлээ дутуу орхих хэрэг гардаг. Библи унших болоод Христэд итгэгчидийн цуглаанд явахын тулд ямар зүйлүүдийг та хийхгүй орхих ёстой болдог вэ?
9. Есүс Марта Мариа хоёрын хэнийг нь илүү хайрлаж байсан бэ?
 - Ишлэл 41, 42-ийн алийг нь Есүс өнөөдөр танд хандаж хэлж байна вэ?
10. Энэ амьдралд болоод үхсний дараах амьдралд хэрэгтэй ганц зүйл бол Бурханы үг билээ. Загалмай дээр байхдаа Есүс яагаад тэр үгийг согсож чадаагүй вэ?

18. Загас уу могой юу? (Лук 11:5-13)

1. Есүс энэхүү сургаалт зүйрлэлээр дамжуулан бидэнд Их Эзэнээс хэрхэн гуйх талаар заахыг хүсчээ. Энэхүү зүйрлэл дээрх хүнтэй ижил төстэй зүйлүүд танд бий юу?
 - Залбирч байхдаа энэ сургаалт зүйрлэл дээр гарч буй хүн шиг Их Эзэнл та шаардлага тавиж байсан уу?
2. Гэр доторхи анд нь гуйсан зүйлийг нь өгөх хүсэлгүй байгаа бололтой. Их Эзэнийг энэхүү "андтай" Есүс яагаад зүйрлүүлсэн бэ?
3. Юу тэр эхний хүнийг хүссэн зүйлээ авахаас нааш тэндээс холдохгүйд хүргэв?
 - Гуйсан зүйлдээ Их Эзэнээс хариу аван автлаа залбирсаар байх тэсвэр тэвчээрийг бид хаанаас авч болох вэ?
4. Ертөнцийн Эзэнтэй хэрхэн ярих ёстойг зааж байхдаа Есүс ГУЙ, ХАЙ, ТОГШ гэсэн 3 үгийг хэрэглэжээ. /9-10/ Энэ үгс ямар утгатай вэ?
 - Та яг одоо юу эрж хайж, тогшиж, гуйж байгаа вэ? /Дотроо хариулж болно/
 - Их Эзэнээс гуйх нь хүүхэд эцгээсээ юм гуйхын адил хэмээн адилтгасан нь бидэнд юу сургаж байна вэ?
5. Тэнгэрлэг эцэг энэ дэлхий дээрх эцэгтэй маань юугаараа адил бэ?
6. Хэрэв хүү нь өөрт нь хор хөнөөлтэй ч юм уу эсвэл шал хэрэггүй зүйл эцгээсээ нэхвэл хүүдээ их хайртай эцэг нь яах бол?
 - Гуйж байгаа зүйл маань бидэнд өөрсдөд маань ч тэр, өрөөл бусдад ч тэр хэрэгтэй эсэхийг бид яаж мэдэж болох вэ?
7. Могой" байх болов уу хэмээн бодож байсан зүйл чинь "могой" биш харин "загас" байсан (эсвэл эсэргээрээ) үе танд тохиолдож байв уу?
8. Гуйлтынхаа хариуг Их Эзэнээс яг одоо авах, хожим мөнхийн улсад авах 2-ын аль нь танд илүү чухал вэ? Яагаад?
9. Исаиа Бурхан бидний гуйлтанд хэрхэн хариу өгдөг тухай доорхи зүйлсийг хэлжээ. /Исаиа 59:1-2/ "Их Эзэний гар нь богинодоод, чих нь хатуудаад л биднийг сонсож чаддаггүй, тусладаггүй юм бишээ. Харин бидний шударга бус байдал нь Их Эзэнийг биднээс холдуулж, гэм нүгэл маань түүнийг биднээс нүүр буруулан чихээ холтгоход хүргэдэг юм" гэжээ.
Доорх асуултанд хариулахдаа энэхүү ишлэлийг сайн бодоорой.
 - Есүсийн ГЕТСЕМАНИ, ГОЛГОТА-д гуйсан гуйлтыг Их Эзэн яагаад сонсоогүй вэ?

19. ТЭНЭГ БАЯН (Лук 12:13-21)

1. Өмч хөрөнгө өвлөх тал дээр ихэнх гэр бшлүүд маргаан зөрчилтэй байдгийг та юу гэж үздэг вэ?
 - 13-р зүйлд гарч буй хүн нь, Есүсээс тусламж хүссэн бусад хүмүүсээс ямар ялгаатай байсан бэ?
2. Тэр хүний гол (хэцүү) асуудал нь юу байсан бэ? /13/
 - Хэрэв Есүс түүний хүсэлтийг ёсоор болгосон бол юу болох байсан бэ?

3. 16-20-р ишлэлүүдийг хар. Энэ баян хүний амьдралыг төсөөл. Аз жаргалтай байсан уу эсвэл үгүй юу? Яагаад?
 - Амьдралых нь цорын ганц асуудал нь 17-р ишлэл дээр дурьдсан асуудалтай тийм амьдралыг та хүүхдүүдээ өгөхийг хүсэж байна уу?
4. ӨӨрт нь нэг удаа ч болов талархаагүй хүний тариалангийн талбай дээр Их Эзэн нар гаргаж бороо оруулсан нь ямар учиртай вэ?
 - Энэ хүний шашин шүтлэг, Бурхан нь юу байсан бэ?
5. Уг баяны хүмүүстэй харьцах харилцааны талаар ямар дүгнэлт хийж болох вэ?
 - Энэ хүний гол алдаа нь юу байсан бэ?
6. Энэхүү сургаалт зүйрлэлийг дэлхийн баян чинээлэг болоод ядуу буурай орнуудын хувьд аваад үз. Үүгээр Есүс бидэнд ямар гэгийг маань ухааруулан ойлгуулахыг хүссэн бэ?
 - Та өөрийн мөнгийг болон байр суурийг хэрхэн ашиглах ёстой вэ?
7. Баян залуу нэг л өдөр үхэх болно гэдгийгээ яагаад бодолцоогүй вэ?
 - Та ямар үед хожим ирэх шүүлт, нүүрлэх үхлийнхээ тухай боддог вэ?
8. 21-р зүйл ямар утгатай вэ? (Мөнхийн улсад баян хүн эд баялгаа яаж хадгалж чадах вэ? Бурханы өмнө "БАЯН" байх гэдэг нь ямар утгатай вэ?)
9. Тэнэг баяныг Есүстэй жишиж үзэхэд тэдний адил ба ялгаатай талууд нь юу байна вэ?
 - Бурхан баян залуугаас амийг нь нэхсэнтэй адил Есүсээс мөн амийг нэхсэн. Яагаад?
 - Есүсийн дэлхий дээр байх үедээ зовж олсон "эд хөрөнгөөс" хэн хуваалцдаг вэ?

20.ҮНЭНЧ БА ҮНЭНЧ БУС БООЛ (Лук 12:35-48)

Суурь ойлголт: "Боол" гэдэг үг нь үйлчлэгч зарц гэсэн утгатай.

35-40-Р ЗҮЙЛ:

1. Шөнө дунд, шүлэг нойрны эхэнд ч унталгүй сэрүүн байхын тулд боол юу хийх хэрэгтэй вэ?
 - Эзэнээ ирэхээс өмнө боол нь унтаж орхисон байвал юу болох вэ?
2. Есүсийг 2-дахь удаагаа ирнэ хэмээн хүлээх нь амархан бэ гэж та бодож байна уу? Яагаад?
 - Есүсийн ирэхийг яагаад хулгайчтай зүйрлэсэн бэ?
3. 35-40-р зүйлүүдээр Есүс бидэнд юу сануулж байна вэ?
 - Та Есүст хэрхэн хаалга нээж өгөж чадах вэ?

41-46-Р ЗҮЙЛ:

4. Сайн, муу 2 гэрийн зохицуулагчдыг хооронд нь харьцуулна уу? Ялгаатай зүйлүүд нь юу байна вэ?
 - Юунаас болж энэ 2 ийм ялгаатай байна вэ?
5. Энэ 2 зохицуулагчийн Эзэндээ хандах хандлагыг нь өөр хооронд нь харьцуул. Тэд бие биеэсээ хир ялгаатай байна вэ?

- Есүсийн дахин ирэх тал дээрх бидний хандлага нь Бурханы хаант улсын төлөө үйлчлэхэд маань хир зэрэг нөлөөтэй вэ?
6. Есүс сүмийнхээ ахлагч нарт өөрийг нь буцаж ирэх хүртэл ямар үрэгийг итгэмжлэн захьсан бэ?
 - Есүс танд ямар даалгавар итгэмжлэн даалгаж байна вэ?
 7. Ууж согтууран, нэгнийгээ зодож занчдаг иймэрхүү сүмийн ахлагч нарыг бид хаанаас олж харж болох вэ?
 - Иймэрхүү итгэгчдийг ямар шийтгэл хүлээж байгаа вэ?

47-48-Р ЗҮЙЛ:

8. Их Эзэнийхээ хүслийг мэддэггүй тийм итгэгч сүмд байдаг нь хэний буруу вэ?
 - Бурханы боолууд энэ дэлхийд төгсгөл ирэх үед хэрхэн шүүгдэх вэ?

ДҮГНЭЛТ:

9. Хаана, хэдийд Есүс бүсээ бүсэлж, биднийг тухлан суухыг урьж, бидэнд үйлчлэх вэ? /37 б/
10. Есүс яагаад хоёр хэсэг хуваалгуулж итгэлгүйчүүдийн эгнээнд шагсаагдан үнэнч бус боолын хувь тавиланг үүрэх болсон бэ?

21. ҮРЖИЛ ШИМГҮЙ ИНЖРИЙН МОД (Лук 13:6-9)

Суурь ойлголт: Уг сургаалт зүйрлэл нь Израйлчуудын талаар өгүүлсэн бөгөөд Есүс 3 жилийн турш энэ үндэстний дотроос үр жимс ургуулах гэж оролджээ. Гэвч энэхүү сургаалт зүйрлэл нь бидний ч талаар хэлж байна. Та нар инжрийн мод бөгөөд Бурхан өөрөө Эзэн нь, Есүс бол модыг арчлан тордогч цэцэрлэгч билээ. Мөн Матайн 21:18-19-г үзнэ үү?

1. Усан үзмийн цэцэрлэгийн хөрс нь голдуу хамгийн сайн л хөрс байдаг. Инжрийн модыг усан үзмийн цэцэрлэгт тарьжээ гэдгээр Есүс юу хэлэхийг хүссэн бэ?
 - Үржил шимгүй инжрийн мод эргэн тойрныхоо бусад моднуудад ямар хор хөнөөл учруулсан бэ?
2. Сүүлчийн 3 жилийн хугацаанд Бурхан таны амьдралаас олж харахыг хүсэн хүлээж байсан үр жимсүүд нь юу байж болох вэ? /Дотроо хариулж болно/
 - Бурханы хаанчлалын төлөө үр жимс ургуулхад чинь юу саад болдог вэ?
3. Үржил шимгүй инжрийн модныхоо талаар цэцэрлэгч нь ямар сэтгэгдэлтэй байсан бэ?
 - Есүс яагаад ямар ч үр жимс ургуулдаггүй итгэгчдийг ч хайрладаг вэ?
4. Есүс эцгийнхээ өмнө зогсоод түүнээс та нарын төлөө хэсэг хугацаа өгөөч хэмээн гуйж байнагээд төсөөл дөө. Юу түүнийг ингэхэд хүргэв?
5. Цэцэрлэгч "хөрсийг нь чийрэгжүүлж, өтгөөр бордъё" гэжээ. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд тэнгэрлэг эцгийнхээ хаанчлалын төлөө үр жимс ургуулахын тулд Есүс таны амьдралд юу хийсэн бэ?
 - Амьдралын тань гуниг зовлон, харамсал, итгэл алдралт зэрэг нь үр жимс ургуулахад чинь хир зэрэг тус дөхөм болсон бэ?
6. Үр жимс үл ургуулагч итгэгчдэд энэ сургаалт зүйрлэлийн дагуу юу тохиолдох вэ?

7. Матайн 21:18-19-г үз. Энэ үйл явдал нь Есүсийн амьдралынх нь хамгийн сүүлчийн 7 хоногт болжээ. Есүс гэнэт үржилгүй инжрийн модыг хараах болсон шалтгааныг бодно уу?
- Энэ 2 ишлэл нь Есүсийн үхэлтэй ямар холбоотой вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс үржил шимгүй инжрийн модыг хараасны дараагаар өөрөө оронд нь тавигдсан – Израйль болон мөн миний, таны ч оронд тавигдсан юм.

22. БӨГТӨР НУРУУТАЙ ЭМЭГТЭЙН ТУХАЙ (Лук 13:10-17)

Суурь ойлголт: Синагог бол Бямба гариг бүрт Бурханы үгийг сонсохоор ирдэг хүмүүсийн цуглардаг газар байжээ. Тэр үед эмэгтэйчүүд хурлын ямарч үйл хэрэгт оролцох эрхгүй зөвхөн арын эгнээ хавиар л суух буюу зогсдог байжээ. Энэ эмэгтэйн нуруу нь яг юу болсоныг мэдэхгүй ч бөгтгөр байсан болов уу гэж таамгалсан юм.

1. Энэ эмэгтэйн тахир дутуу явсан 18 жилийн амьдралыг төсөөлөн бод. Ямархуу байсан бол?
 - Бөгтөр нуруутай энэ эмэгтэйд бусад хүмүүс хэрхэн хандаж байсан бол? /14/
2. Хэрэв та залуухнаараа тахир дутуу боолчихвол хамгийн хэцүү зүйл чинь юу байх вэ?
 - Таныг залуу байх үед ийм азгүй явдал тохиолдвол үүнийг зөвшөөрсөн Их Эзэний талаар та юу бодох вэ?
3. Есүс муу сүнсэнд эзэмдүүлсэн хүмүүсийг эдгээхдээ тэрхүү сүнсстэй шууд харьцдаг. Харин энэ эмэгтэйн тохиолдолд тэгээгүй нь эмэгтэй муу сүнсэнд эзэмдүүлэгийг харуулж байна. Есүс түүнд "сатан таныг хүлжээ" гэж хэлсэн нь ямар утгатай вэ?
 - Хүмүүсийг сэтгэл дүүрэн амьдрахад юу саад хүлээс болдог вэ?
4. Энэ эмэгтэй өвчнөө эдгээлгэх гэж сүмд ирээгүй нь лавтай. Тэр яах гэж сүмд ирсэн бэ?
 - Долоо хоногт ганц удаа Бурханы үгийг сонсох нь энэ эмэгтэйн хувьд ямар учиртай байв.
5. Эмэгтэй Есүсээс яагаад тусламж хүсээгүй вэ?
 - Есүс түүнийг олны өмнө дуудаж гаргахад түүнд ямар сэтгэгдэл төрсөн бол?
 - Юунаас болж эмэгтэй Есүсийн хэлсний дагуу хийсэн бэ?
6. Энэ сэдэвийн дагуу бол сатанд хүлэгдсэн хүсүүст юу тусалдаг вэ?
7. Ямар утгаар Есүс энэ эмэгтэйг "Абрахаамын охин" гэж хэлсэн бэ?
8. Синагогийн ахлагч, Есүс 2-ын энэ эмэгтэйд хандах хандлага нь хир ялгаатай байв?
 - Синагогийн ахлагч өөрийгөө Бурханд итгэдэг гэж бодож явжээ. Түүний итгэлд юу дутагдаж байна вэ?
 - Синагогийн ахлагч юунд хүлүүлсэн байсан бэ?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс өөрөө Сатанд хүлүүлж, загалмайд хадагдсан билээ. Тиймээс чөлөөлөгдөхийг хүссэн хүн болгоныг Есүс Сатаны дарлалаас чөлөөлж чадах болжээ.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

23. ДАВЧУУ ХААЛГА (Лук 13:22-30)

1. Яагаад хүмүүс 23-р ишлэл дээрх асуултын хариуг мэдэхийг хүсдэг гэж та бодож байна вэ?

- Энэ асуултанд Есүс яагаад зүгээр л тийм эсвэл үгүй гэж хариулаагүй вэ?
2. Бурханы хаанчлалд орох хаалга нь ямар үед нарийн давчуу байдаг вэ?
 - Ямар төрлийн хүмүүст энэ хаалга нь илүү давчуу байдаг вэ?
 3. Энэ давчуу хаалгаар орох гэж хүмүүс янз бүрээр оролддог. Тэд ямар ямар замаар орох гэж оролддог вэ? (24)
 4. Үүнтэй холбоотойгоор Есүс Бурханы хаанчлал дахь найрын тухай сургаалт зүйрлэл хэлсэн байна. /25-27/ Үүгээр Есүс сүнсүж байгаа хүсүүст юу хэлэхийг хүссэн бэ?
 5. Энэхүү давчуу хаалгаар орох хангалттай хугацаа байсаар байхад сургаалт зүйрлэл дээрх эдгээр хүмүүс яагаад ороогүй вэ?
 - Энэ зүйрлэл нь 23-р ишлэлтэй ямар холбоотой вэ?
 6. Түүнтэй хамт хооллож, сургаалыг нь сонсдог байсан тэдгээр хүмүүсийг Есүс "Би та нарыг танихгүй" гэж хэлсэн нь ямар утгатай вэ?
 - Сүүлчийн тэр өдөр Есүс биднийг таньж угтана гэдэгт бид хир итгэлтэй байж чадах вэ?
 7. 28 дээр дурьдагдсан эдгээр зөнчид ч гэм нүгэлтэй, дутагдал доголдолтой хүмүүс байсан. Тэдэнд юу Бурханы хаанчлал дахь тэр давчуу хаалгаар ороход тус болсон бэ? /Түүхийг дахин сөхөж харалгүйгээр, тэдгээр зөнчдийн талаар сонссон дуулсан зүйл дээрээ үндэслэж ярь/
 - Бурханы хаант улсын найранд ирэх бусад хүмүүс нь хэн бэ? /29/
 8. Удирдагч Иоханы 10:9-ийг уншина уу? Мөнхийн улсад орох хаалганы тухай энэ сургаал нь юу өгүүлж байна вэ?
 - Яагаад Есүсийн мөнхийн улсруу орох хаалганы тухай сургаал нь ийнхүү зөрж байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Хуулийг дагаснаараа гэмт хүн аврагдах ямарч боломжгүй бөгөөд энэ нь үлгэрлэвээс тэмээ зүүний сүвэгчээр орох гэж зүтгэхтэй адил юм. /Матай 19:24/ Зөвхөн Есүс л энэ хуулийн хаалгаар орж чадсан билээ. Харин БАЯРЫН МЭДЭЭ-ний үүд хаалга нь гэм нүглийг уучлагч хаалга бөгөөд хүн бүрт нээлттэй байдаг.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

24. ИХ ЗООГ (Лук 14:12-24)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Эхэнд уригдагсад нь үнэндээ Еврейчүүд байжээ. Их Эзэн Библийн үг болон баптисмаар дамжуулан хүмүүсийг урьж дуудсан. 16-20-р зүйлийг эдгээр дуудагдсан бүх хүмүүст хамааруулж болох юм.

1. Хамгийн сүүлд хэдийд найр хийснээ та сана даа. Хэрэв хэн нэгэн хүн танд 12-14-р зүйлд бичигдсний дагуу үйлд гэж хэлбэл та яах вэ?
 - Есүс яагаад ядуу зүдүү, өвчтэй зовлонтой хүмүүсийг дайлаасай хэмээн биднээс хүсч байна вэ?
2. 18-20 зүйлийг хар. Найранд очихоос татгалзсан тэр 3 хүний яг жинхэнэ шалтаг нь юунд байсан бэ?
 - Хүмүүс бид яагаад Бурханы хаанчлалаас илүүтэйгээр өөрсдийн өв хөрөнгө /18/, ажил үйлс /19/, хайр дурлалаа /20/ эрхэмлдэг вэ?
 - Таны амьдралд энэ 3-ын аль нь илүү зонхилдог вэ? /Дотроо бодож болно/
3. Уригдсан хүн найрын эзнийг хир хүндэлж байна вэ?

- Уригдсан хүн хариу урьж чадахгүй байх хэмээн айсандаа найранд ирэхээс татгалзсан байж болох юм. /12 б/ Хэрэв тийм бол энэ нь ирэхээс татгалзсан эдгээр хүмүүсийн тухай юу өгүүлж байна вэ?
 - Ирэхээс татгалзсан эдгээр хүмүүсийн хамгийн том алдаа нь юунд байсан бэ?
4. Сургаалт зүйрлэл дээрх найраар Мөнхийн улсыг төлөөлүүлсэн байдаг. Яагаад ихэнхи хүмүүс энэ газар очихыг сонирхдоггүй вэ?
 5. Эхэнд уригдагсад болоод найранд сүүлд очигсдын хоорондох гол ялгаа нь юу байсан бэ?
 - Эхний хэсэг хүмүүс урилгыг хүлээж аваагүй байхад сүүлийн хэсэг нь яагаад хүлээж авах болов?
 6. Мөнхийн улсад хүрэх урилгыг дуртайяа хүлээж авах ядуу, тахир дутуу, хазгар доголон, сохор хүмүүс гэдгээр хэний тухай хэлсэн вэ? (21)
 - Энэ хүмүүс дайллаганд нь хариу барих талаар яагаад санаа зовохгүй вэ?
 7. 23-р ишлэл хэнд хамааралтай вэ?
 - Уг ишлэл нь авралын зарын талаар бидэнд юу гэж сургаж байна вэ?
 8. Энэ 2 бүлэг хүмүүсийн алинд нь та багтах вэ? /Дотроо хариулж болно./
 - Урилгыг хүлээж авахаас татгалзагчдын бүлгээс хүлээн авагчдын бүлэг рүү шилжүүлэхийн тулд таны амьдралд Бурхан ямар зүйлийг хийсэн бэ?
 9. Бурханы "Зоог бэлэн болов. Морилон ирцгээнэ үү" хэмээх урилгыг хүргэхээр илгээгдсэн боол бол ЕСҮС өөрөө байсан юм. /17/ Есүс энэ зоогыг бидэнд барихын тулд ямар үнэ төлөх хэрэгтэй болсон бэ?
 - Есүс танд "Зоог бэлэн боллоо. Морилон ирнэ үү" гэж хэлж байна. Та хариуд нь юу хэлмээр байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Мөнхийн улсын найранд орохын тулд Есүс өөрөө ядуу, тахир дутуу, хазгар доголон, сохор болох хэрэгтэй болсон юм. Тийнхүү найранд орохыг хүсэгч хэн бүхэн чөлөөтэй уригдах болсон байна.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

25. ТӨӨРСӨН ХОНИНЫ ТУХАЙ (Лук 15:1-7)

1. Татвар хураагчид болон нүгэлтнүүд Бурханы дуу хоолойг сонсохооргүй алс хол төөрсөн байдаг шалтгаануудыг нэрлэнэ үү? /1/
 - Бид ч бас заримдаа Их Эзэний дуу хоолойноос зугтан холуур хэсүүчлэхийг хүсдэг нь юуных вэ?
2. Төөрсөн хонь эзэндээ буцаж очихын тулд юу хийх хэрэгтэй вэ? Мөн юуг хийж болохгүй вэ?
 - Гэмт хүн Есүс Эзэнд дээр очихын тулд юу хийх хэрэгтэй вэ? Юуг хийж болохгүй вэ?
 - Энэ сургаалт зүйлээр бидний санааг зовоож буй хүмүүст хамаарах ямар тайвшралыг өгүүлсэн бэ?
3. Төөрсөн хонь эргэж олдохыг Есүс гэмшилтэй зүйрлэжээ. /7/ Тэгвэл энэ сургаалт үлгэрийн дагуу гэмшил гэдэг нь юу гэсэн утгатай вэ? /Сэдвээ сайн эргэцүүл/
4. Гэмших шаардлагагүй зөв хүмүүсийг хаанаас олж болно гэж та бодож бйана вэ? /7/
 - Исаакын номонд Фарисайчуудын сайн мэдэх ийм нэгэн ишлэл байдаг. "Бид бүгдээрээ төөрсөн хонь мэт өөр өөрсдийнхөө замаар будилж явцгаана. Гэвч Их Эзэн бидний хүртэх тэр шийтгэлийг өөртөө авчээ..." /Исаак 53:6/ Тэдгээр гэмших

шаардлагагүй 99 гэж хэн бэ?

5. Фарисайчууд юу гэж гэмших ёстой байсан бэ? /2/
 - Фарисайчууд төөрч будилж яваагаа яагаад мэдээгүй явсан бэ?
 - Олдсон, алдагдсан 2 бүлгийн алинд нь та өөрийгөө хамаарна гэж бодож байна вэ?
6. Сургаалт зүйрлэлүүд дээрх хурим найр нь Бурханы хаанчлал дахь Мөнхийн улсыг төлөөлсөн байдаг. Яагаад алдагдсан нэг хонь л тэр найранд ороод үлдсэн 99 нь орж чадаагүй вэ? /6/
7. Хэн ч өөрсдийн 2 хөлөөр Бурханы хаанчлалд орж чадахгүй гэсэн нь ямар утгатай вэ? /8/
8. Гэм нүгэлтэнгүүдийг хүлээн авч, тэдэнтэй хамт хооллогч Есүстэй өнөө үед бид хаана уулзаж болох вэ? /2/

БАЯРТ МЭДЭЭ: Иохан баптист Есүсийг хоньтой зүйрлэсэн байдаг. Ертөнцийн гэмийг үүрэгч Бурханы хурга "Иохан 1: 29" Бурханы Хурга Есүс нь зэрлэг зэлүүд энэ газраас аврагдаагүй харин ч тэнд алагдахын тулд иржээ. Түүнийг хэн ч хурга мэт гэр лүү нь үүрч яваагүй хаин тэр бидний бүх гэмийг үүрсэн юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

26. ТӨӨРСӨН ХҮҮГИЙН ТУХАЙ (Лук 15:11-24)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Дундад Дорныхон нь хүн ам шигүү суурьшсан тосгоны замын дагуу амьдардаг бөгөөд тэд байшингаа дов толгод дээр барьдаггүй ажээ. Алсын бараа харж болох цорын ганц газар гэвэл байшингийнх нь дээвэр юм. Тэндхийн нэр хүнд бүхий хүмүүс хэзээ ч гүйдэггүй гэнэ.

1. Сайн эцэг, сайхан орон гэртэй байсан хирнээ бага хүү яагаад амьдралдаа сэтгэл хангалуун бус байсан бэ?
 - Хэрэв та эцгийнх нь оронд байсан бол хүүгийн хүсэлтэнд хэрхэн хариу өгөх байсан бэ?
2. Өөрийг нь орхиж явахаар зэхэж буй хүнд Ертөнцийн Эзэн яагаад хориг тавьж саад хийдэггүй вэ?
3. Бага хүүгийн гэрээсээ яваад амьдрарсан амьдрал нь жаргалтай байсан гэж та бодож байна уу үгүй юу?
 - Өнөө үед, олон хүмүүс яагаад их мөнгө өвөртлөн, хаа сайгүй аялан тэнүүчилж, маргаашдаа санаа зовох юмгүй амьдрахыг эрхэмлэх болсон бэ?
4. Еврейчүүд гахайг бузар амьтанд тооцдог байжээ. Бага хүү нь 14-16 дээр бичигдсэнтэй адил нөхцөлд орчихоод өөрийхөө талаар юу гэж бодсон бол?
 - Ийм байдалд орчихоод байж байхдаа бага хүүд ямар сонголтууд байсан бэ?
 - Таны өнөөдрийн Их Эзэнтэй харьцдаг харилцаанд ямар сонголтууд байгаа вэ?
5. Хүү өөрийн гэмийг гэмшсэн талаар 18-19 зүйлүүдэд өгүүлжээ. Тэнгэрийн эсрэг түүний үйлдсэн гэм нь юу байсан бэ? Яагаад үүнийгээ эхэлж гэмшсэн бэ?
 - Тэр эцгийнхээ эсрэг ямар гэм үйлдсэн байсан бэ?
6. Ямар нөхцөл байдалд орохоороо бид нар энэхүү үрэлгэн хүүгийн адил "Бурханы хүү хэмээгдэх нь зохисгүй" гэж бодох хандлагатай болдог вэ? /19/
 - Хүн хэдийд "Бурханы хүү" хэмээн дуудагдах эрхтэй болдог вэ?

7. Хүү эцэгтээ хэлэхээр төлөвлөж байсан үгээ яагаад бүгдийг нь гүйцэт хэлээгүй вэ? /18-19; 20/
8. Хүүгээ эзгүй эдгээр жилүүдэд эцэг нь юу хийж байсан бэ? /20/
 - Эцэг нь хүүгээ хэдийд уучилсан гэж та бодож байна вэ?
 - Хүү нь эцгийнхээ хайранд хэдийнээс итгэж эхэлсэн бэ?
9. Энэ сургаалт зүйрлэлийн аль хэсэгт нь Есүс гарч байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Үрэлгэн хүүгийн тухай сургаалт зүйрлэл нь нөгөө талаар бидэнд Есүсийн тухай өгүүлж байна. Есүс ч өөрийн орон гэр болоод тэнгэр дэх эцгээ орхин явсан боловч огт өөр шалтгаанаар эцгийнхээ хүсэлтийг биелүүлэхийн тулд тийнхүү явсан юм. Харин түүнийг гэртээ эргэж очиход үрэлгэн хүүг угтсан шиг зочлол байсангүй. Харин ч түүний өмнө хаалга чангаар хаагджээ. Яагаад вэ?

27. ТОМ ХҮҮГИЙН ТУХАЙ (Лук 15:25-32)

1. Дүү нь гэрээ орхиод явсан шиг ах нь яагаад яваагүй вэ?
 - Энэ хүн юуг бүхнээс илүүтэйгээр хүсэж байсан бэ?
 - Том хүүгийн амьдрал яагаад баяр баясгалангаар дутмаг байсан бэ?
2. Том хүү өөрийгөө өв залгамжлагч гэхээсээ илүү зарц барлаг мэтээр үздэг байсан нь юуных вэ? /26, 29, 31/
 - Энэ хүү яагаад эцгийнхээ үгэнд итгээгүй вэ?
3. Ямар үед та өөрийгөө "өнчин ишигний" ч шан харамж горьдолгүйгээр Бурханы хаант улсын төлөө зүтгэн ажилласан гэж бодож байсан бэ? /29/
4. Эцгийгээ найранд орохыг гуйхад нь том хүү татгалзан бүх л тосгоныхоны өмнө эцэгийнхээ нүүрийг улайлган эвгүй байдалд оруулжээ. Ийнхүү эцгийгээ үл хайрлах шалтгаан нь юу байсан бол?
 - Энэ сургаалт зүйрлэлээс харахад бид ямар шалтгаанаас болж Бурханыг хайрлахгүй болдог вэ?
5. Том хүү нь өөрийгөө "Би эцгийнхээ хэлсэн болгоныг л биелүүлдэг" гэж боддог байсан боловч үнэндээ тийм биш байсан. /29/ Эцэг нь хүүгээсээ яг үнэндээ юуг хүсэж байсан бэ?
 - Ихээхэн итгэлтэй гэгддэг хүмүүс ч гэсэн яагаад зарим үед ямар ч бодлогогүйгээр Бурханы хүслийн эсрэг зүйлүүдийг хийдэг вэ?
6. Есүсийн сургаалт зүйрлэлүүдэд гарч байгаа ихэнх найр наадам нь мөнхийн улсыг төлөөлсөн байдаг. Энэ сэдвээс үзэхэд хэн нь мөнхийн улсад очиж чадах вэ?
7. Есүс яагаад сургаалт зүйрлэлээ дуусгаагүй вэ? (32)
8. Маргааш өглөө нь ах дүү 2 талбайд ажиллахаар хамт явлаа гэж бодоход тэдний бодол санаа хир зэрэг зөрөөтэй байсан гэж та бодож байна вэ?
9. Энэ сургаалт зүйрлэлийн аль хэсэгт нь Есүс гарч байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс ч энэ том хүүгийн адил өв залгамжлагч байсан. Гэвч энэ бүхнийгээ орхиж загалмайд үхэх боолын замыг сонгож авсан юм. /Фил 2:6-8/ Ийнхүү энэ том хүү шиг өөрөө өөрийгөө боолчилсон хүмүүсийг Есүс чөлөөлж, хүссэн хэнд ч болов тэрээр мөнхийн өвийг гардуулах болно.

28. БАЯН ХҮН ЛАЗАР 2-ЫН ТУХАЙ (Лук 16:19-31)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Абрахам бол Еврейчүүдийн өвөг эцэг бөгөөд Христ Итгэгчдийн итгэлийнх нь ч эцэг билээ. Тэрээр маш баян хүн байжээ. "Лаазар" хэмээх нэр нь "Бурхан тусалсан хүн" эсвэл зүгээр л "Бурхан тусласан" гэсэн утгатай. Зөвхөн энэ сургаал зүйрлэл дээр Есүс хүнд нэр өгсөн юм. "Мосэ болон Зөнчид" бол "Хуучин гэрээ" номны хураангуйлал юм.

1. Баян хүн амьдралдаа ямар зүйлсээр зугаацан цэнгэж байсан бол? Боллоцоотой бүхнийг нэрлэнэ үү?
 - Лазарыг дэлхий дээр байх үед нь түүний амьдралд сайн зүйл гэж байсан гэж та бодож байна уу?
2. Баян гэрээсээ гадагш гарах болгондоо Лазарыг хардаг байсан атлаа яагаад түүнд тусладаггүй байсан бэ?
 - Лазарт баян хэрхэн хандсантай адилаар хэн нэгэн хүн хүүхдэд чинь хандвал та түүнд ямар шийтгэл оноох вэ?
 - Өнөө үед бид бүгдийн туслаж болох Лазар шиг хүмүүс нь хэн бэ?
3. Эцэг эх нь хүүхдэдээ яагаад "Бурхан туслагч тэр хүн" гэдэг нэр өгсөн бэ? Олон шаалганыг олно уу.
 - Лазарт Бурхан туслаж байсан уу?
 - Есүс сургаалт зүйрлэлдээ яагаад энэ нэрийг сонгсон бэ?
4. Лазар залбирах бүртээ л "Намайг эрүүл саруул, идэх хоолтой байлгаж өгөөч" хэмээн гуйдаг байсан биз ээ. Гэтэл энэ бүхэнд нь хариу өгөөгүй тэр Эзэнд Лаазар итгэлтэй байсаар байсан нь ямар учиртай вэ?
 - Хэрэв Лазар Бурханд итгээгүй байсан бол амьдрал нь ямархуу байх байсан бол?
5. Магадгүй Лазарыг үхэхэд оршуулах ёслол хийлгүйгээр, зүгээр л ядуусын булшинд аваачаад хаячихсан биз ээ. Харин баяныг нас барахад нь булшлав гэж сэдэвт бичигджээ. /22/ Баян хүний оршуулган дээр хүмүүс юу гэж үг хэлсэн бол?
6. Баян хүн яагаад тамд орох болов. /Дээрх тайлбарыг үз/
 - Ямар учраас Лазар мөнхийн улсад орохоор зөвшөөрөгдсөн бэ?
7. 27-31 дээр хүмүүс хэрхэн аврагдах тухай Абрахамтай баян ярилцсан тухай бичжээ. Баян хүн авралын талаар юу гэж бодож байсан бэ?
 - Абрахамын хэлсэнээр бол гайхамшиг яагаад итгэлийг төрүүлж чадахгүй вэ?
8. Хүн авралыг яагаад Библигүйгээр авч чаддаггүй вэ? /29-31/
9. Лаазарын амьдрал болоод үхэл нь Есүсийхтэй юугаараа төстөй вэ? (Тэдний итгэл, амьдрал, зовлон гэх мэтийг авч хэлэлц)
 - Дахин амилах тухайгаа Есүс хэрхэн урьдчилан хэлсэн бэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

29. АРАВ ЭДГЭРЧ НЭГ НЬ АВРАГДАВ (Лук 17:11-19)

Суурь ойлголт: Есүсийн тэр үед уяман өвчтэй хүмүүс жирийн хүмүүстэй цуг байж болохгүй, бусдаас тусгаарлагдан амьдардаг байжээ. Өвчтөн өөрийгөө эдгэрсэн гэж үзвэл биеэ тахилчид очиж үзүүлэх ба хэрэв биеэр нь тархсан яр өвчин арилсан байвал тахилч түүнийг эдгэрч цэвэр болсныг бусдад зарлан мэдэгддэг байв. (Левит 13, 14) Хуучин гэрээ номонд зөвхөн хоёр гуравхан л ийм гайхамшигтай үйлийн тухай бичсэн байдаг. Үүнээс гадна Иүдейчүүд Самари хүмүүсийг харийнхантай холилдсон гэж дургүйцэн гадуурхдаг байжээ.

1. Эдгээр хүмүүс уяман өвчин туссанаа мэдсэн тэр өдрийн тухай бодоцгооё. Тэр даруй тэдний толгойд гэр орныхон нь болоод ирээдүйн амьдрал нь хэрхэн төсөөлөгдөж байсан бол?
 - Өнөө үед ДОХ өвчин нь Есүсийн үеийн уяман өвчинтэй хир ижил төстөй өвчин бэ?
2. Эдгээр өрөвдөлтэй хүмүүсийн амьдралынх нь хамгийн гэрэл гэгээтэй зүйлс нь юу байсан бэ?
3. Есүсийг өөрсдийнх нь төлөө юу хийх бол хэмээн тэд горьдож байсан бэ? 13-р зүйлээс тэдний залбиралыг харна уу.
4. Самари, Галилейн хоорондын хилээс 50-60 кмт тахилчид оршин суудаг байжээ. Есүс яагаад эдгээр хүмүүсийг тэнд нь эдгээггүй харин хол газар луу явуулсан юм болоо?
 - Тэд хараахан эдгэрээгүй байсан ч яагаад энэ хол хэцүү аян замд гарах болсон бэ?
 - Ийнхүү замд гарахаар бэлэн болсон эдгээр 10-н хүмүүсийг та итгэгч гэх үү эсвэл үл итгэгч гэх үү?
5. Иүдейн тахилчид Самари хүний төлөө ямар нэг юм хийхийг огтхон ч хүсэхгүй байдаг байжээ. Үүнийг мэдсээр байж Самари хүн яагаад бусдынхаа адил тийш зүглэх болов?
6. Яагаад нөгөө есөн Иүдей нь буцан ирж Есүст талархалаа илэрхийлээгүй юм бол? Бололцоотой бүх шалтгаануудыг хэлнэ үү.
 - Харин яагаад ганц Самари хүн л ирж Есүст талархалаа илэрхийлсэн бэ?
7. Буцаж ирээгүй 9-ийн төлөө Есүс яагаад сэтгэл нь зовох болов?
 - Та хэзээ нэгэн цагт ийнхүү энэ 9 шиг Есүсийн урмыг хугалаж байсан уу?
8. "Итгэл чинь чамайг эдгээлээ" гэсэн нь өөр утгаараа "Итгэл чинь чамайг аварлаа" гэсэн үг юм. Есүс яагаад Самари хүнд ийнхүү хулхийг хүссэн бэ?
9. Өвчнөө эдгээлгэхээр Есүсийг хайж байсан итгэлээс Есүсийг өөрийг нь хайх итгэл юугаараа ялгаатай вэ?
 - Өвчнөө л эдгээлгэх гэсэн итгэл нь авралд яагаад хангалттай бус вэ?
10. Есөн Иүдей хүмүүс өвчтэй бас тусгаарлагдсан амьдралч байсан он жилүүдээ хожим эдгэрсэн хойноо дурсан санахад тэдэнд ямархуу сэтгэгдэл төрж байсан бол?
 - Самари хүний хувьд өвчтэй байсан он жилүүд нь ямар утгатай байв?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс бас загалмай дээр энэ өвчтөнүүд шиг зовж шаналан гадуурхагдаж байсан. "Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд өвчин зойлонг тэдсэн.....Үнэхээр Тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав" (Исаиа 53:3-4) Энэ нь хийсэн гайхамшгийнхаа төлөө төлсөн үнэ байсан юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

30. ШҮҮГЧ БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙ 2 (Лук 18:1-8)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Есүсийн үед эмэгтэй хүн хэн нэгэнийг шүүхээр заалдах болоод шүүхэд гэрчээр оролцох эрхгүй байсан бөгөөд иймэрхүү ажлыг тэдний садангийн эрэгтэй хүн хөөцөлдөж өгдөг байсан байна. Гэвч энэ эмэгтэйн хувьд гэвэл тусламж дэмжлэг болчихоор хүн түүнд байсангүй. Магадгүй хамаатан садангийнхан нь хүүхдийнх нь өв залгамжлалыг булаацалдаж байсан биз ээ.

1. Бурханд хандан өдөр шөнөгүй гүйж гувшиж байсан үеэ дурсан санана уу? Яагаад ийм үед хүн амархан сэтгэл алдран залбирахаа орхидог вэ? (1, 7)
2. Энэ бэлэвсэн эмэгтэй орь ганцаар үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх гэж хир их зовж зүдэрсэн бол? Амьдралыг нь төсөөл.
3. Юунаас болж хүмүүс сургаалт зүйрлэл дээрх энэ шүүгч шиг Бурханаас үл эмээгч, бусдыг үл хүндлэгч болдог вэ? (2)
 - Есүс Бурханыг яагаад энэ зөв бус шүүгчтэй харьцуулсан бэ?
 - Танд Бурхан зөв бус шүүгчийн адил байсан гэсэн сэтгэгдэл ер нь төрж байсан уу? Тийм бол хэдийд вэ?
4. Шүүгчийг өөртөө туслана гэдэгт бэлэвсэн эмэгтэй итгэл дүүрэн байсан байна. Яагаад тэр вэ?
 - Хайртай хүмүүст маань болоод бидэнд өөрсдөд маань Их Эзэн гарцаагүй туслана гэдэгт бид хир итгэлтэй байж болох вэ?
5. Эмэгтэй удаан хугацааны турш цөхрөлтгүй гуйсаар байсан билээ. Энэ үед тэр эмэгтэйн зүрх сэтгэл ямар байсан бол?
 - Бид Их Эзэнээс гуйгаад удтал хариугаа авахгүй бол сэтгэл маань ямархуу болдог билээ?
6. 7-8 дээрх Есүсийн хэлсэн үгс ямар утга илэрхийлж байна вэ?
7. Есүс ч гэсэн шүүгчийн өмнө нэг удаа зогсож байсан билээ. Тэдний шүүгч дээр очих болсон явдлын адил төстэй болоод ялгаатай талууд нь юу байна бэ? /Библиэс харалгүйгээр мэдэх зүйл дээрээ түшиглэн саналаа солилцоорой./
 - Есүсийн залбирал энэ эмэгтэйн залбирлаас хир зэрэг ялгаатай бэ? /3/
 - Есүсийн бодол эмэгтэйнхээс яагаад өөр байсан бэ?
 - Есүсийн талаарх Бурханы бодол зөв байсан уу? Эсвэл үгүй юү?
8. "Харин хүний хүү газар дээр ирэхдээ итгэл олох болов уу" гэсэн нь энэ сургаалт зүйрлэлтэй ямар холбоотой вэ? /8б/
9. Энэ сургаалт зүйрлэлээс та хувьдаа залбиралын талаар юу сурав? /1, 5, 7, 8-р ишлэлүүд/

БАЯРТ МЭДЭЭ: Пилат Есүсийг үхэл руу нь илгээсэн тэр үед шудрага бус шүүгч болсон юм. Харин Бурхан Есүсийг үхэл руу нь элгээсэн нь таны болон миний бид бүгдийн нүгэлийн төлөө байсан бөгөөд тэр зөв шудрага шүүгч юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

31. ХЭН НЬ ЗӨВТ ВЭ? (Лук 18:9-14)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Энэхүү сургаалт зүйрлэл нь зөв шударгын онолын талаарх чухал сургаал юм. Энэ онол нь "Явал бид Бурханы өмнө зөвд тооцогдож түүний хаанчлалд багтах вэ?" гэсэн асуултанд хариу өгдөг юм. Есүсийн үед хүмүүс Фарисайчуудыг Бурханаас эмээж түүнд итгэлтэйгээр үйлчилдэг зөв хүмүүс гэж ойлгодог байсанаас биш тэднийг өөрөө өөрсдийгөө өргөмжлөн зөвтгөгч, хуурамч 2 нүүртэнгүүд гэдгийг нь мэддэггүй байжээ. Тэд ядуусын талд ордог байсан учир эгэл олны дунд тэд нэр хүндтэй байдаг байлаа. Харин татвар хураагчид бол ядуусыг мөлжигч, эх нутгаасаа урван тэрслэгчид хэмээн нүд үзүүлэгддэг байжээ.

1. Энэ 2-ыг Их Эзэнд итгэдэг байсан гэж гэрчлэх ямар шинж тэмдгүүд байна вэ?
 - Еврейчүүдийн хувьд сүм дугана бол Бурхантай ойр байх, гэм нүглээ илчлэн хүлээх газар нь байлаа. Сэдэвт гарч байгаа Фарисай хүн ямар учраас сүмд орж ирсэн бэ?

- Татвар хураагч ямар учраас сүмд орж ирсэн бэ?
2. Фарисай хүн юунд талархаж байсан бэ? Түүний залбиралыг хар.
 - Тэр залбиралдаа Бурханы өөрт нь хийж өгсөн зүйлүүдийн тухай огтхон ч дурсаагүй нь ямар учиртай вэ?
 - Фарисай хүн зөвт байдлын тухай ямар ойлголттой байсан бэ?
 3. Энэ татвар хураагч хүнийх шиг залбиралаар та залбирч байсан уу? /Дотроо хариулж болно./
 - Татвар хураагчын залбиралын Грек хэл дээрх утга нь "Бурхан минь би танд өргөл өргөж байгаа учир гэмт намайг өршөөгөөч" гэсэн ажээ. Тэр зөвт байхын талаар ямар ойлголттой байсан бэ?
 4. Юугаараа бид энэ Фарисай хүнтэй адил вэ?
 - Энэ Фарисай хүний Бурханы өмнө болоод эргэн тойрныхоныхоо өмнө үйлдсэн гэм нүглүүд нь юу байв?
 - Фарисай хүн өөрийнхөө үйлддэг гэмүүдийн ядаж нэгийг нь ч болов яагаад анзаараагүй байсан бэ?
 5. Фарисай хүний итгэл нь татвар хураагчийн итгэлээс илүү байжээ. Яагаад буруу итгэл нь зөвөөсөө илүү хүчтэй байдаг вэ?
 6. Эдгээр хүмүүс сүмээс гараад явахдаа аль нь зөв шударга байсаныг хэн мэдэж байсан бэ?
 - Есүс яагаад энэ сургаалт үлгэрээ татвар хураагч нь бүсдаас авсан зүйлээ буцаан өгч тэднийг хохиролгүй болгосон гэж төгсгөөгүй вэ?
 7. Энэ татвар хураагч олон хүний амьдралыг хохироосон нь лавтай.
 - Үүнийхээ төлөө тэр ямар шийтгэл хүлээх вэ?
 8. Хүн зөвтөгдөнө гэдэг нь ямар утгатай вэ?
 - Зөвтгөлийн тэл дээр Бурхан ямар үүрэгтэй вэ?
 - Зөвтрөлийн тал дээр өргөл нь ямар учиртай вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Сүм дугануудад өргөгдөж байсан өргөл нь Есүсийн үхлийн утгыг харуулж байсан юм. Тэгээд ч татвар хураагч Есүсийн золиосын үндсэн дээр уучлалыг хүссэн ажээ. Түүний үйлдсэн бүх гэм нүглүүд нь Есүст өгөгдсөн бөгөөд Есүсийн зөвтгөл түүнд өгөгдсөн юм.

32. МОДОН ДЭЭРХ ТАТВАР ХУРААГЧ (Лук 19:1-10)

СУУРЬ ОЙЛШОЛТ: Есүсийн амьдарч байсан тухайн цаг үед татвар хураагчид нь зальхайгаараа нэрд гарсан улс байжээ. Тэд хүмүүсээс их хэмжээний татвар авч ихэнхийг нь өөрсдөө завшдаг байв. Бид Есүсийг залилуулсан ба ядуу хүмүүсийн талд байдаг гэж боддог боловч энэ хэсэгт Есүс залилагчын талд оржээ. Еврейчүүдийн заншил ёсоор бол хэн нэгнийд хооллохоор очих нь нөхөрлөлийн илрэл ажээ.

1. Иерехогын ахлагч татвар хураагч Закхайн амьдрал ямар байсан бол? Түүний сайн муу талууд нь юу байсан бэ?
2. Закхай өөрийн ажил хөдөлмөр, амьдралынхаа хэлбэрийг хэрхэн зөвтгөн үздэг байв?
 - Тэр яагаад их мөнгөтэй болохыг хүсч байсан бэ?
3. Закхай Есүстэй уулзахыг ихэд хүссэн нь ямар учиртай байсан бол?

- Татвар хураагчдын ахлагч хүн олны өмнө модонд авираастай харагдахыг хүсч байсан болов уу?
4. Мөнгийг чинь хэн нэгэн хүн шударга бусаар булааж авч байсан тэр үеэ бод. Закхай мэт хүмүүсийн золиос болж тийнхүү хохирсон бол 5-р зүйл дээрх Есүсийн үйлдэл чамд ямар сэтгэгдэл төрүүлэх вэ?
 5. Закхайг анх хараад Есүсийн хэлсэн үгэнд гайхалтай зүйл юу байв? /Есүс анхны болоод эцсийн удаагаа Иерехү хотод ирсэн нь энэ байжээ гэдгийг санаарай/
 6. Закхай хэзээнээс Есүст итгэж эхэлсэн гэж та бодож байна вэ? (5-8)
 7. Хэрэв Есүс Закхайд "Доошоо бууж ирээд өв хөрөнгөнийхөө талыг ядууст тарааж өг. Тэгвэл би танайд очно" гэж хэлсэн бол тэр яах байсан бол?
 - Хэрэв Есүс танд "Эхлээд гэм буруугаа хүлээ. Тэгсэний чинь дараа би таны найз болох болно" гэвэл та яах вэ?
 8. Ганцхан өдрийн дотор л эд баялгынхаа 70%-ийг тарааж үгүй болгоно гэдэг ямар байхыг төсөөл. Юунаас болж ийнхүү үйлдэнэ гэж та бодож байна?
 - Эд баялгаасаа татгалзаад Закхай оронд нь юу олж хүртсэн бэ?
 9. 7-р зүйлээс харахад Закхай болон Иерихо хотынхны хооронд ямар том ялгаа байна вэ?
 - Тосогны хамгийн нэр хүндгүй муу хүнийд Есүс яагаад очихыг хүссэн бэ?
 10. Есүс танд яг одоо "Би өнөөдөр танайд очих болно" гэж хэлж байна. Та түүнд юу гэж хариулах вэ?
 11. Энэ Библийн хэсэгт хэн нь ханийгээ хайж байсан бэ? Есүс Закхайг уу эсвэл Закхай Есүсийг үү?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс цовдлогдохоосоо өмнөхөн Иерихо хот руу тойрч очжээ. Тэр Закхайн төлөө л тийнхүү явсан байж болох юм. Есүс Закхайн гэмийг уучилж байхдаа түүний гэмийн төлөөс болон Бурханы шийтгэлийг амсах болно гэдгээ мэдэж байсан. Гэм нүгэлийн уучлал нь Закхайд үнэгүй өгөгдсөн ба бидэнд ч мөн адил – харин Есүс амиараа төлсөн юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

33. ХАМГИЙН СҮҮЛЧИЙН СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ (Лук 20:9-19)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Усан үзмийн цэцэрлэгээр анхлан Еврейчүүдийг, ялангуяа тэдний удирдагчдыг зүйрлүүлдэг байсан бөгөөд сүүлдээ Христэд итгэгчдийн сүмийг төлөөлүүлэн зүйрлэдэг болжээ.

1. Түрээслэгчид усан үзмийн цэцэрлэгийн эзнийг ямар хүн байх нь зүйтэй гэж үзэж байсан бэ?
 - Цэцэрлэгийн Эзний талаарх тэдний бодолд ямар алдаа байсан бэ?
 - Бурхан, хүн 2-ын хоорондын харилцаа ямар байгаасай гэж хүссэндээ Есүс энэ сургаалт зүйрлэлээр харуулсан бэ?
2. Эхний боолоо гар хоосон буцаж ирэхэд нь Эзэн нь яагаад хүн явуулахаа зогсоогоогүй вэ? /10/
 - Түрээслэгчид боолуудад яагаад улам бүр харгис хэрцгий хандах болсон бэ? (10-12)

- Бурхан өөрийн зарц нараа яагаад хавчигдан гадуурхагдаж, жанчигдахаас нь сэргийлж хамгаалдаггүй вэ?
3. Бурханы биднээс авахыг хүсч буй үр жимс нь юу вэ?
 - Манай сүмээс авахыг хүсэж буй үр жимс нь юу вэ?
 - Бурханд өөрсдийн үйлсийн жимсийг өгөх нь яагаад заримдаа хэцүү байдаг вэ?
 4. Юу бодож тэр Эзэн усан үзмийн цэцэрлэг рүү хайртай ганц хүүгээ илгээсэн бэ?
 - Ямар шалтгаанаар та хайртай ганц хүүгээ иймэрхүү аюултай газарлуу явуулж чадах вэ?
 - Энэ дэлхий Бурханы хувьд өөрийн хайртай ганц хүүгээ явуулхаас өөр аргагүй их чухал байсаны учир юу вэ?
 5. Түрээслэгчдийг Эзнийхээ хүүг алахаас буцахгүй тийм хатуу харгис байдалд хүрэхэд юу нөлөөлсөн бэ?
 - Бурханы хүүг хөнөөх тийм хатуу сэтгэл хөмүүст юунаас болж төрөх болсон бэ?
 - Ямар учраас бид Есүсийн үхэлийн төлөө хариуцлагатай болсон вэ?
 6. Есүсийн үхлийн төлөө хариуцлага хүлээгсдэд юу тохиолдох вэ? /16/
 - 16-р ишлэлийг Хрисчин сүмд хэрхэн хамааруулж ойлгох вэ?
 7. Энэ сургаалт зүйрлэлээ дуусгаад Есүс өөрийнхөө үхлийн тухай өөр нэгэн жишээ авчээ: Барилгын булангын чулуу. 17-18-р ишлэлүүд ямар утга илэрхийлж байна вэ?
 - Ямар учраас сүм цуглаанууд болон итгэгч хүмүүс итгэлийнхээ булангын чулууг авч хаядаг вэ?
 8. Есүс энэ сургаалт зүйрлэлээрээ Еврейчүүдийн удирдагч нарт юу хэлэхийг хүссэн бэ?
 - Энэхүү зүйрлэлээр Есүс бидэнд юу хэлэхийг хүсч байна вэ?
 - Есүс энэ сургаалт зүйрлэлээрээ өнөөдрийн сүм цуглааны ахлагч нарт юу хэлэхийг хүссэн бэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

34. БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙН ӨРГӨЛ (Лук 21:1-4)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Хуучин гэрээнд бэлэвсэн эмэгтэйчүүд болон өнчин хүмүүст хандсан олон амлалтууд байдаг. Жишээлбэл: Дуулал 10:14,17,18 мөн Дуулал 98:5. Энэ хэсэг дээр гарч буй бэлэвсэн эмэгтэй энэхүү амлалтуудыг сонсож байсан байхаа. Өргөлийг сүм барихад зоиурлдаг байсан бөгөөд сүмийг 63 онд барьж дууссан бөгөөд 70 онд нураажээ. Энэ нь энэ хэсэг дээрх болсон явдлаас хойш ойролцоогоор 40 жилийн дараа юм.

1. Яагаад бүх шашинд өргөл өргөх гэж байдаг вэ?
 - Маркын бичсэнээр бол эрднэсийн сан нь хүн болгонд харагдахаар газар байдаг байсан. (Марк 12:41)Бусад хүмүүс хэн хэр их өргөл өргөж байгааг харж болдог нь өргөж байгаа хүнд хэрхэн нөлөөлөж болох вэ?
 - Бэлэвсэн эмэгтэй өөрийг нь Есүс ажиглаж байгааг мэдсэн бол түүнд ямар сэтгэгдэл төрөх байсан бол?
2. Тэр үед нийтийн хамгаалалтын систем гэж байдаггүй байсан бөгөөд эмэгтэй хүмүүсийг гадуур гарч ажил хийхийг хориголдог байжээ. Ийм үед нөхөр төнь нас бараад та

хүүхдүүдээ тэжээх хэрэгтэй гээд төсөөлөөд үз. Таны хувьд хамгийн хэцүү зүйл нь юу байх вэ?

- Хэрвээ та дээрх шиг байдалд орсон байсан бол та хэнд юунд сүүлчийнхээ мөнгийг өгөх вэ?
3. Юу хүнийг "амь зуухад хэрэгтэй байсан бүхнээ" Бурханд өргөхөд хүргэх вэ?
 4. Хэрвээ Бурхан эмэгтэйг байгаа бүхнээ өг гэж албадсан бол эмэгтэй Түүний талаар юу гэж бодох байсан бэ?
 - Дараах 2 хүний итгэл нь юугаараа ялгаатай вэ: Бурханд өргөл өргөж мөн түүнээс авсан зүйлийнхээ төлөө талархаж буй хүн ба Бурханаас ямар нэгэн зүйл авахын тулд өргөл өргөж буй хүн.
 5. Бэлэвсэн эмэгтэйн итгэл ямар байсан бэ?
 - Бурхан түүний хүүхдүүдийг халамжлах болно гэдэгт тэр хэрхэн итгэлтэй байж чадсан бэ?
 - Бурхан танд болон таны хүүхдүүдэд санхүүгээр туслах болно гэдэгт итгэх хэцүү юу?
 6. Бэлэвсэн эмэгтэй Бурханаас юу авсан бэ?
 - Та Бурханаас юу авсан бэ? (энэ эмэгтэй хүнтэй өөрийгөө харьцуул)
 7. Тэр орио эмэгтэйн хүүхдүүд ходоод хоосон орондоо орцгоосон гэж та бодож байна уу?
 - Аль нь таны хүүхдүүд ач зээ нэрт илүү хор хөнөөлтэй вэ: Гачигдлаас болж зовлон амсах эсвэл хүссэн бүхнээ авах?
 8. Бурхан таныг өөрт нь эсвэл зовж буй хөршдөө ямар өргөл өргөхийг хүсэж байгаа вэ? (Та үүнийг дотроо хариулж болно)
 9. Энэ эмэгтэй хүүхдүүддээ өв болгож юу үлдээсэн бол?
 - Энэхүү сэдэвт гарч буй баян хүмүүсийн хүүхдүүддээ үлдээсэн өвийг эмэгтэйн үдээсэн өвтэй харьцуул.
 - Та нас барахдаа хүүхдүүддээ юуг үлдээхийг хүссэж байна вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Библи дээр бидний гэм нүгэлийг тодорхой хэмжээний мөнгөн дүнтэй (10000 талэнт) адил үздэг. Өрөө төлж чадахгүй хэнч бай шоронд орох болно(там). Есүс биднийг чөлөөлөхийн тулд энэхүү асар их өрөнд амь зуухад хэрэгтэй байсан бүхнээ өгсөн юм мөн өөрийн цусыг урсгасан.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

35. ПЕТР ЭЗНЭЭСЭЭ УРВАСАН НЬ (Лук 22:31-33; 54-62)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Удирдагч Матайн 10:32-33-ийг унших ба сонсогчид хамгийн ноцтой гэм нүгэл бол бусдын өмнө Есүсийнх гэдгээ үл хүлээх явдал юм гэдгийг ойлгох нь чухал.

1. Таны хамгийн хайртай дотны хүн чинь танд "Та надаас урвах болно" гэж урьдчлан сануулвал танд ямар сэтгэгдэл төрөх бэ?
 - Есүсийн сануулганд Петр яагаад итгээгүй вэ? /34/
2. Петр бусад дагалдагчидтайгаа явалгүйгээр сүмийн тэргүүний гэр хүртэл Есүсийг дагасаар явсан нь ямар учиртай вэ?
3. Есүсээс гурав дахь удаагаа урвасны дараагаар Петр юунаас их айсан бэ?

- Та Петрийн оронд байсан бол яах байсан бэ?
 - Ямархуу нөхцөл байдал дунд та өөрийгөө Христчин итгэлээсээ урвахаас аргагүй тийм сорилтонд ороод байгаа мэт санадаг вэ?
4. 61-р ишлэл дээр Есүс сүүлчийн удаа Петр лүү эргэж харсан тухай бичжээ. Түүний харцаар бол Есүс өөрт нь үнэнч байж чадаагүй дагалдагчиддаа юу хэлэхийг хүсч байсан бол?
 - Петр юунаас болж гадагшаа гарч гашуудан уйлсан бэ? /62/
 5. Яг энэ зүйл болсоны дараахан нь Петр Есүсийн өдөр нь хэлсэн үгний талаар юу гэж бодсон бэ? /31-34/
 - Өөрийнх нь төлөө Есүс гуйн залбирч байсан гэдгийг Петр сонсоод юу бодсон бол?
 6. Петр урьд нь Есүсийг алагдах тухайгаа ярихад нь Түүний бодлыг хүчтэйгээр няцааж байсан билээ. Энэхүү үйл явдлын дараагаар Петр Есүсийг яагаад заавал үхэх ёстой байсан талаар юу ойлгосон бэ?
 7. Энэ үйл явдал нь Петрт бусаддаа урам өгөх хүчийг хэр хайрласан бэ?
 - Бид гэм нүгэлд унаснаараа ах дүүсдээ урам зориг өгөж чадах уу?
 8. Петрийг урвасных нь дараахан Есүс түүн рүү ширтэн харсан шигээ тань руу ч одоо харж байна. Түүний харц танд юу өгүүлж байгаа бол?

БАЯРТ МЭДЭЭ: Хэдийгээр Петр өөрийн багш Их Эзэнийг бусдын өмнө үгүйсгэн түүнээс урвасан боловч уучлагдсан билээ. Есүсийг бүх хүн төрөлхтөний гэмийг үүрэн загалмайд шийтгүүлэх үед Эцэг нь түүнийг үгүйсгэсэн юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

36. МӨНХИЙН УЛСЫН ҮҮД НЭЭГДЛЭЭ (Лук 23:32-43)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Есүсийн үед зөвхөн ноцтой гэмт хэрэг хийсэн хүмүүсийг л цовдолж шийтгэдэг байжээ. Тэгвэл энэ 2 дээрэмчин мөнгөнөөс болж хүн алсан юм уу эсвэл өөр ямар нэгэн ноцтой гэмт хэрэг хийсэн бололтой.

1. Энэ 2 хүнийг хулгай хийх, хүн алах гэх мэт нүглүүдийг үйлдүүлэх болсон шалтгаан нь юу вэ?
 - Энэ мөчийг хүртлээ тэд гэм нүглээ яагаад хаяагүй вэ?
 - Бусдад төдийгүй өөрсдөд маань хор хөнөөл болохыг мэдсээр байж яагаад бид муу зуршлаасаа салах дургүй байдаг вэ?
 - Энэ 2 хүнд ээж мөн эхнэр гэж байсан байх. Эдгээр эмэгтэйчүүдийн өдөр тутамын амьдралыг төсөөл.
2. Тэр 2 дээрэмчин Есүсийг цовдлогдож байх үед бусдаас илүү ойрхон байсан. Тэдний нэгнийх нь сэтгэлийг Есүсийн ямар байдал хөндөж чадсан бэ?
 - Энэхүү дээрэмчид үзэн ядалт болон өршөөн авалтын ертөнцөд амьдардаг байсан байхаа. Гэвч Есүсийн 34-р зүйл дээрх залбиралын тухай тэд юу бодсон бол? (34-38)
3. Тэдний нэг нь гэмээ ухаарахад юу нөлөөлсөн бэ?
 - Юу биднийг өөрсдийгөө өмгөөлж хамгаалах гэлгүйгээр гэм нүглээ хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг вэ?
4. Тэдний нэг нь Есүсийг хаан гэж бодсоны учир юу вэ? (37, 38, 42)
 - Бусад хаадуудтай харьцуулахад Есүс тэр үед яг ямар хаан байсан бэ?

5. Нөгөө нэг дээрэмчин нь Есүсийг хаан эсвэл Христ гэдэгт яагаад итгээгүй вэ?
 - Бид яагаад итгэлээс урьдаар гэмээ ухамсарлах ёстой байдаг вэ?
6. 42-р зүйл дээр “Есүс ээ мөнхийн улсдаа орохдоо намайг санаарай” гэсэн богино залбирал бий. Тэр яагаад “намайг мөнхийн улсдаа оруулаач” гуйгаагүй вэ?
 - Биднийг зовож байх үед хэн нэг нь биднийг сандаг нь яагаад тайвшарлыг өгдөг вэ?
 - Шийтгэлээр тамд эдлэнэ гэдгээ мэдэж байсан алуурчин яагаад Есүсийг өөрийг нь санаасай гэж хүссэн бэ?
 - Танд иймэрхүү залбиралаар залбирах тохиолдол хэдийд гарч болох бол?
7. Уг гэмт хэрэгтэн хэдийд аврагдсан бэ?
 - Энэ хүний гэм нүгэл нь юу болсон бэ?
8. Энэ дээрэмчин Христэд итгэснийхээ дараахан, 6-хан цагийн дараа нас барсан. Тэр сүүлчийнхаа цаг мөчид аз жаргалтай байсан болв уу?
 - Тэр яг үхэх үедээ хэн нэгэнийг үзэн ядаж байсан болов уу?
 - Хүн ёсоор бол энэ дээрэмчин өөрийн амьдралаа сүйрүүлсэн. Гэвч түүний амьдрал хэрхэн чухал ач холбогдолтой болж хувирсан бэ?

БАЯРТ МЭДЭЭ: Адам Ева 2-ын үеэс эхлээд л мөнхийн улсын хаалга гэмт хүмүүст хаалттай болсон юм. Гэвч одоо энэ хаалга алуурчин, гэмт хэрэгтнүүдэд ч нээгдэж байна. Яг энэ үед Есүсийн өмнө энэ хаалга хаагдаж Тэр бүх хүн төрөлхтөний шийтгэлийг үүрч тамын хаалгаар орсон юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

37. ЕММАУ ХҮРЭХ ЗАМД (Лук 24:13-35)

СУУРЬ ОЙЛГОЛТ: Еммау нь Иерусалимаас 11 км орших тосгон юм. Энэ нь алхахад 2 цаг гаран явж хүрэх ажээ. Есүсийн загалмайн дэргэд Клеопын эхнэр Мариа... нар зогсож байсан юм. /Иохан 19:25/ Мариа энэ сэдэвт гарч буй Клеопын эхнэр байсан бололтой.

1. Хэрвээ та хэзээ нэгэн цагт хайртай хэн нэгнээсээ хагацаж үзсэн бол оршуулсныхан дараагаар ямар их хэцүү үй гашуу сэтгэлд чинь бөглөрөн байдгийг мэднэ биз ээ. Энэ тухайгаа хуваалцна уу?
 - Есүс маш зэрлэгээр алагдсанаас хойш хоёр хоног л өнгөрөөд байжээ. Энэ хооронд Клеоп болон түүний найзуудад хамгийн хүнд хэцүү санагдаж байсан зүйл нь юу байсан бол оо?
2. Есүс яагаад энэ 2 хүнийг эхлж гашуудлаа илэрхийлэхийг зөвшөөрсөн бэ? /15-17/
 - Есүс шууд л Библийг тайлбарлаж эхэлсэн бол юу болох байсан бэ?
 - Бидний зовлон гачаалыг Есүс тэртэй тэргүй мэдэж байдаг хэрнээ яагаад эн тухай заавал биднээс өөрсдөөс маань сонсохыг хүсдэг вэ?
3. Есүсийг нас барсанаас хойш энэ хоёр хүний итгэл хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? /19-21/
 - Тэр хоёр, эмэгтэйчүүдийн болон бусад хүмүүсийн гэрчлэн ярьсан зүйлд яагаад итгэж чадахгүй байсна бэ? /22-24/
4. Өөрийнхөө үхлийн талаар Есүсийн өгсөн тайлбар нь Клеоп болон түүний найз хоёрын өгсөн тайлбараас хэр ялгаатай байсан вэ? /19-21; 25-27/
5. Өөрийнхөө алдрыг дуурсгахын тул Христ энэ бүх зовлонг эдлэх тухай Мосэгээс эхлэн бүх зөнчдийн хэлсэн үгийг Клеоп яагаад ойлгоогүй байсан бэ?

6. Есүс яагаад цаашаа явах маяг үзүүлсэн бэ? /28/
7. Есүсийг талх хуваах хүртэл нь тэр хоёр яагаад таниагүй бэ?
8. Юу тэр хоёрыг харанхуй шөнөөр дахин Иерусалим хүртэл 11 км газрыг туулахад хүргэсэн бэ?
9. Өөрсдийгөө Христэд итгэгч хэмээн нэрлэгч олон хүн Есүсийн махан биеийн дахин амилалтанд итгэдэггүй. Тэд ямархуу Бурханд итгэгчид вэ?
 - Есүс Христийн махан биеийн дахин амилалтанд үл итгэгч хүн яагаад Христэд итгэгч байж чадахгүй вэ?

БАЯРТ МЭДЭЭ: Есүс Клеопын гэрт талхыг өөрийн соривтой 2 гараараа хуваасан. Тэр хоёр хүн түүнийг соривоор нь таньсан биз ээ. Үүнтэй адилаар Эзэний ариун зоогыг барих бүрдээ бид дахин амилсан Есүстэй уулзаж болох юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - www.gladtidings-bs.com

38. БҮХ ҮНДЭСТЭНД (Лук 24:44-53)

1. Есүс дагалдагчиддаа юу тунхаглахыг, мөн хаана тунхаглах ёстойг үүрэг болгосон бэ?
 - Есүс ячмар ч боловсролгүй 11 хүнд иймэрхүү үүрэг даалгаварыг өгөх болсоны учир юу вэ?
2. Хуучин гэрээг ойлгох оюун ухааныг тэдэнд юу нээж өгсөн бэ?
 - Бидэнд Хуучин гэрээг ойлгуулахын тулд юу болох ёстой вэ?
3. Есүс дагалдагчдаа "гэрч" хэмээн нэрлэсэн байна. /48/ Тэд юун тухай гэрчлэл хийх ёстой вэ?
 - Бид хэнд, юун тухай гэрчлэх ёстой вэ?
4. Гэрч гэдэг үг нь "зовогч" гэсэн утгаар орчуулагдаж болох юм. Авралын зарыг тунхаглахын тулд амиа ч өгөхөөс буцахгүй болоход дагалдагчидад юу нөлөөлсөн бэ?
5. Есүс өөрийн дагалдагчдад дээрээс хүчийг илгээнэ хэмээн амалжээ. Энэхүү хүч нь Есүсийн тухай гэрчлэл хийхэд яагаад зайлшгүй чухал хэрэгтэй байдаг бэ?
 - Та тэрхүү дээрээс ирэх хүчийг авсан уу? Авсан бол яаж авсан вэ?
6. Агуу авралын зар тараагч Паул энэ дээрээс ирэх хүчний тухай ийнхүү тодорхойлсон байдаг. /Ром 1:16; 2Коринт 12:9-10 уншина уу/ Их Эзэний хүч нь "ХҮЧ" хэмээх үгний жирийн нэг утгаас ялгаатай болохыг хэлэлцэнэ үү.
7. Энэ сэдвийн дагуу авралын зарыг тунхаглагч болох нь ямар утгатай вэ?
8. Есүс яагаад энэ дэлхий дээр биеээрээ үлдээгүй вэ?
 - Есүс тэнгэр өөд хэрхэн одсон вэ?
 - Дагалдагчид Их Эзнээсээ салсан ч гэсэн баяр хөөртэй байсан нь юуных вэ?
9. Дагалдагчид тэнгэр өөд одож буй Есүстэй ярилцахад дэлхий дээрх Есүстэй ярьж байгаа мэт хялбархан байсан болов уу?
 - Есүс таны хажууд таны үл харагдах найз мэт байдаг гэдэгийг та байнга ухаарч явдаг уу?

БАЯРТ МЭДЭЭ: Мөнхийн улсад Есүсийн хийж буй зүйлийн тухай Еврей 7:25д бий.